



**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ**



**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ, ШҮҮХИЙН  
ТАМГЫН ГАЗРЫН 2018 ОНЫ ЖИЛИЙН  
АЖЛЫН ТАЙЛАН**

**Улаанбаатар хот  
2018 он**



## ГАРЧИГ

1. Илтгэгчийн үг: Тамгын газрын дарга Ж.Наранпүрэв	2-3
2. Улсын Дээд шүүхийн 2018 оны ажлын тайлангийн товч танилцуулга	4-5
3. Эрүүгийн хэргийн танхимын шүүн таслах ажлын тайлан	6-10
4. Иргэний хэргийн танхимын шүүн таслах ажлын тайлан	11-16
5. Захиргааны хэргийн танхимын шүүн таслах ажлын тайлан	17-22
6. Бусад асуудлаар	23-26
7. Тамгын газрын ажлын тайлан	27
8. Захиргаа удирдлагын хэлтсийн ажлын тайлан	27-33
9. Шүүхийн практик судлалын хэлтсийн ажлын тайлан	33-37
10. Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн ажлын тайлан	37-43
11. Шүүхийн зохион байгуулалтын хэлтсийн ажлын тайлан	43-44
12. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн ажлын тайлан	44-45
13. Ерөнхий шүүгчийн ажлын албаны ажлын тайлан	45-47
14. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны ажлын тайлан	47-51
15. Сургалт семинар	51-60



## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ, ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН 2018 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

*Илтгэгч: Тамгын газрын дарга Ж.Наранпүрэв*

Эрхэм хүндэт шүүгч, ажилтнуудаа!

Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Өнгөрч буй онд бид шүүхийн шинэтгэлийг амжилттай үргэлжлүүлж, шүүн таслах болон шүүхийн захиргааны ажлын талаар багагүй үр дүнд хүрч, түүнийгээ тайлагнах гэж буйд хувьдаа баяртай байна.

Энэ хугацаанд шүүх, шүүгчийн үндсэн хэрэглээ болсон салбарын суурь шинжтэй материаллаг болон процессын цөөнгүй хууль тогтоомж шинэчлэн найруулагдаж батлагдсан бөгөөд үүнд тус шүүхийн Танхимын тэргүүнүүд болон шүүгч, захиргааны ажилтнууд идэвхитэй ажиллаж, хууль зүйн шинжлэх ухааны хөгжилд болон шүүхээс хууль хэрэглэх асуудалд зарчмын өөрчлөлт, хүний эрх, эрх чөлөөг шүүхийн журмаар нөхөн сэргээх, баталгаажуулахад дэвшил гарсныг дурдахад таатай байна.

Тулгар төр байгуулагдсаны 2227, Их Монгол улсын 812, Үндэсний эрх чөлөөний хувьсгалын 107, Ардын хувьсгалын 97 жил, Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гаргаж, шүүхийн байгууллагад олон жил, үр бүтээлтэй ажилласан Улсын Дээд шүүхийн Техник, үйлчилгээний ажил хариуцсан ахлах шинжээч **С.Баасанцэрэнг** “Алтангадас” одонгоор, Мэдээлэл лавлагааны ажил хариуцсан ахлах шинжээч **Б.Чимгээ**, мужаан **Б.Пүрэвээ** нарыг “Хөдөлмөрийн хүндэт” медалиар тус тус шагнажээ.






Мөн Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын шүүгч **Ц.Амарсайхан** Шүүхийн Ерөнхий зөвлөлийн “**Шударга ёсны элч**” тэмдгээр, Архивын ажил хариуцсан ахлах мэргэжилтэн **Ж.Тэгшдэлгэр** Шүүхийн Ерөнхий зөвлөлийн “**Хүндэт**” тэмдгээр, Мэдээллийн технологи хариуцсан референт **Э.Баярбаатар**, Компьютерийн техник хангамжийн ажил хариуцсан ахлах шинжээч **Ж.Эрдэнэ** нар “**Мэдээлэл, харилцаа холбооны тэргүүний ажилтан**” тэмдгээр тус тус шагнагдсан байна.






## УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН 2018 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

Улсын Дээд шүүхийн нийт хүлээж авсан 3764 хэргээс:




Шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн 3017 хэргээс:






Улсын Дээд шүүхийн эрүү, иргэн болон захиргааны хэргийн танхимуудын  
2018 онд хүлээж авсан хэргийг өмнөх онтой харьцуулбал:



2018 онд шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэргийг өмнөх  
онтой харьцуулбал:



Улсын Дээд шүүхийн нэг шүүгчид ногдох хэргийн ажлын ачааллыг өмнөх онтой  
харьцуулбал:





# **ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ**






## НЭГ. ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

### 1.1. Эрүүгийн хэргийн танхим.

Эрүүгийн хэргийн танхим 2017 оны үлдэгдэл **34** хэрэг дээр 2018 онд хяналтын шатны журмаар эрүүгийн **826**, цагаатгалын **1**, нийт **861** хэрэг хүлээн авч, эрүүгийн **572**, цагаатгалын **1** буюу нийт **573** хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, **190** хэргийг шүүгчийн захирамжаар буцааж, **91** хэргийг Ерөнхий шүүгчийн ажлын албанд шилжүүлж, **7** хэргийн үлдэгдэлтэй байна.

### Нийт хүлээн авсан эрүүгийн 861 хэргээс:



Эрүүгийн хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаан нийт **68** өдөр хуралдаж, өдөрт дунджаар **8.4** хэрэг хэлэлцжээ.

Эрүүгийн хэргийн танхимд хяналтын шатны журмаар ирүүлсэн **770** хэргээс нэг шүүгчид **192.5** хэрэг ногдож байна.

Хяналтын журмаар шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэгдсэн **573** хэргийн **46.4** хувь буюу **266** хэргийн тогтоол, магадлалыг хэвээр үлдээж, гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож, **26.5** хувь буюу **152** хэргийн тогтоол,






магадлалд өөрчлөлт оруулж, **27** хувь буюу **155** хэргийн тогтоол, магадлалыг хүчингүй болгожээ.

Өөрчлөлт оруулсан **152** хэргийн **32.9** хувь буюу **50** хэргийг Эрүүгийн хууль буруу тайлбарлан хэрэглэсэн, **7.2** хувь буюу **11** хэргийг хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, **10.5** хувь буюу **16** хэргийг шүүх хэрэглэвэл зохих хууль хэрэглээгүй, **2.6** хувь буюу **4** хэргийг зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хүндрүүлсэн, **16.5** хувь буюу **25** хэргийг зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлсэн, **30.3** хувь буюу **46** хэргийг бусад гэсэн үндэслэлээр тус тус өөрчлөлт оруулжээ.

Хүчингүй болгосон **155** хэргийн **49** хувь буюу **76** хэргийг **шүүхээр дахин хэлэлцүүлэхээр** буцааж, **6.4** хувь буюу **10** хэргийг (үүнээс 10 хувь буюу 1 нь цагаатгалын хэрэг) **хэрэгсэхгүй** болгож, **44.5** хувь буюу **69** хэргийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, магадлалыг хүчингүй болгожээ.

Хяналтын журмаар Танхимын тэргүүн Б.Цогт **4**, шүүгч Д.Ганзориг **192**, Д.Эрдэнэбалсүрэн **192**, Б.Батцэрэн **191**, Ч.Хосбаяр **191**, Ерөнхий шүүгчийн ажлын алба **91** эрүүгийн хэрэг тус тус хүлээн авчээ.

#### Шүүгч тус бүрийн болон Ерөнхий шүүгчийн ажлын албаны хүлээн авсан хэрэг




Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Б.Цогт **573**, шүүгч Д.Ганзориг **573**, Д.Эрдэнэбалсүрэн **573**, Б.Батцэрэн **545**, Ч.Хосбаяр **519**, С.Батдэлгэр **82** удаа тус тус **оролцсоноос**;



Танхимын тэргүүн Б.Цогт **569**, шүүгч Б.Батцэрэн **4** хэргийн шүүх хуралдааныг даргалж;

Танхимын тэргүүн Б.Цогт **4**, шүүгч Ч.Хосбаяр **148**, Д.Эрдэнэбалсүрэн **148**, Д.Ганзориг **141**, Б.Батцэрэн **132** хэрэг илтгэсэн байна.

**Эрүүгийн хэргийн танхимын шүүгчдийн 2018 оны бүтэн жилийн ажлын ачаалал:**



2018 онд цагаатгал хариуцсан шинжээчээс Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн төрөл садан болон Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссуудаар дамжуулан **115** өргөдөл, хүсэлтийг хүлээн авч нийтдээ **51** цагаатгалын үнэмлэх олгосноос **30** үнэмлэх шинээр, **21** үнэмлэх нөхөн олгож, цагаатгуулах болон нөхөн олговор олгуулахаар ирүүлсэн **13** хүсэлтийг харьяаллын дагуу зохих байгууллагуудад шилжүүлсэн болно.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн цагаатгалын **1** хүнд холбогдох **1** хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгаж шийдвэрлэжээ.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **80.4** хувь буюу **461** хэргийг ялтан, хохирогч, тэдний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн гомдлоор, **1.4** хувь буюу **8** хэргийг иргэний нэхэмжлэгч, хариуцагчийн гомдлоор, **16** хувь буюу **92** хэргийг улсын яллагчийн эсэргүүцлээр, **2.1** хувь буюу **12** хэргийг прокурорын дүгнэлтээр хэлэлцэгджээ.



Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **573** хэргийг гэмт хэргийн төрлөөр авч үзвэл:

- Хүнийг алах гэмт хэрэг - **87**,
- Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэрэг - **69**,
- Хулгайлах гэмт хэрэг - **67**,
- Залилах гэмт хэрэг - **58**,
- Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг - **56**,
- Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах гэмт хэрэг - **50**,
- Хүчиндэх гэмт хэрэг - **49**,
- Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах гэмт хэрэг - **21**,
- Хөрөнгө завших гэмт хэрэг - **11**,
- Дээрэмдэх гэмт хэрэг - **8**,
- Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг - **8**,
- Хахууль авах гэмт хэрэг - **8**,
- Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах гэмт хэрэг - **5**,
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг - **5**,
- Мал хулгайлах гэмт хэрэг - **2**,
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг - **2**,
- Хахууль өгөх гэмт хэрэг - **1**,
- бусад төрлийн гэмт хэрэг - **66** байна.

Тайлангийн хугацаанд шүүгч Б.Батцэрэн **55**, Д.Эрдэнэбалсүрэн **50**, Ч.Хосбаяр **43**, Д.Ганзориг **42**, нийт **190** хэргийг хянаж шүүгчийн захирамж болон шүүхийн тогтоолоор буцаасан байна.

Эрүүгийн хэргийн танхим 2018 онд нийт **114** албан бичиг, **47** өргөдөл гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн Б.Цогт **73** албан бичиг, **24** өргөдөл гомдол, шүүгч С.Батдэлгэр **33** албан бичиг, **22** өргөдөл гомдол, шүүгч Д.Эрдэнэбалсүрэн **3** албан бичиг, **1** өргөдөл гомдол, шүүгч Ч.Хосбаяр **3** албан бичиг, шүүгч Б.Батцэрэн **1** албан бичиг, шүүгч Д.Ганзориг **1** албан бичиг тус тус хянан шийдвэрлэж, одоо албан бичиг, өргөдөл гомдлын үлдэгдэлгүй байна.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний захирамж **770** гарснаас шүүхийн харьяалал тогтоох тухай **76**, хэрэг хянан шийдвэрлэх хугацаа сунгах тухай **67**, шүүх бүрэлдэхүүн томилох тухай **627** захирамж гарчээ. Мөн



тайлангийн хугацаанд шүүгчийн захирамж **189**, шүүхийн тогтоол **49**, мэдэгдэх хуудас **156** гарсан байна.

Улсын дээд шүүхийн хяналтын шатны Эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанаар хянан шийдвэрлэгдсэн **19** хэргийн **57.9** хувь буюу **11** хэргийн хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол, шүүгчийн захирамжийг хэвээр үлдээж, гомдлыг хэрэгсэхгүй болгож, **10.5** хувь буюу **2** хэргийн хяналтын шатны шүүх хуралдааны тогтоолд өөрчлөлт оруулж, **31.6** хувь буюу **6** хэргийн хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол, шүүгчийн захирамжийг хүчингүй болгожээ.

Улсын дээд шүүхийн хяналтын шатны Эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **15.8** хувь буюу **3** хэргийг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн дүгнэлтээр, **5.3** хувь буюу **1** хэргийг хоёр шүүгчийн тусгай санал гаргасан үндэслэлээр, **5.3** хувь буюу **1** хэргийг Улсын ерөнхий прокурорын эсэргүүцлээр, **73.6** буюу **14** хэргийг ялтан, хохирогч, тэдний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн гомдлоор хэлэлцжээ.



# ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМ



## 1.2. Иргэний хэргийн танхим.

Иргэний хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл **162** хэрэг дээр хяналтын шатны журмаар **1942**, шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар **56**, Ерөнхий шүүгчийн ажлын албанд **3**, нийт **2163** хэрэг хүлээн авч, **1932** хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, **55** хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар хэлэлцэж, **74** хэргийг хяналтын журмаар хэлэлцэхээс татгалзаж, **13** хэргийн харьяаллыг тогтоосон байна. Иргэний хэргийн танхим үлдэгдэл **89** хэрэгтэй байна.

### Нийт хүлээн авсан 2163 хэргээс



**Иргэний хэргийн танхимын** хяналтын шатны шүүх хуралдаанаар нийт **98** өдөр хуралдаж, өдөрт дунджаар **20** хэрэг хэлэлцжээ.

Иргэний хэргийн танхимд хяналтын шатны журмаар ирүүлсэн **2150** хэргээс нэг шүүгчид **307.1** хэрэг тус тус ногдож байна.

Хяналтын журмаар хэлэлцэгдсэн иргэний **1932** хэргийн **56.7** хувь буюу **1096** хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, **10.8** хувь буюу **208** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцааж, **18.5** хувь буюу **357** хэргийн шийдвэр, магадлалд нэмэлт, өөрчлөлт



оруулж, **10.6** хувь буюу **206** хэргийн магадлалыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчилж, **3.4** хувь буюу **65** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон байна.

Өөрчлөлт оруулсан **357** шийдвэр, магадлалын **57.4** хувь буюу **205** нь хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хууль хэрэглэсэн, хууль буруу тайлбарлаж хэрэглэсэн, **42.6** хувь буюу **152** нь шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн үндэслэлээр шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулжээ.


Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож хэргийн дахин хэлэлцүүлэхээр буцаасан **208** хэргийн **53.4** хувь буюу **111** хэргийг шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй гэж, **46.6** хувь буюу **97** хэргийг шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн үндэслэлээр шийдвэр, магадлалыг тус тус хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаажээ.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг буюу хэргийг хэрэгсэхгүй болгосон **65** хэргийн **58.5** хувь буюу **38** нь шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, **41.5** хувь буюу **27** нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн байна.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай **55** хэргийн **54** хэргийн хүсэлтийг хангаагүй, **1** хэргийн хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн байна.

**Хяналтын журмаар** Шүүгч Г.Алтанчимэг **309**, П.Золзаяа **309**, Б.Ундрах **305**, Г.Цагаанцоож **303**, Д.Цолмон **289**, Х.Эрдэнэсүвд **289**, Ц.Амарсайхан **287** хэрэг хүлээн авчээ.

#### Шүүгч тус бүрийн хүлээн авсан хэрэг








**Хяналтын шатны** Иргэний хэргийн шүүх хуралдаанд шүүгч Танхимын тэргүүн Х.Сонинбаяр **1426**, шүүгч Г.Цагаанцоож **1362**, Г.Алтанчимэг **1323**, П.Золзаяа **1207**, Х.Эрдэнэсүвд **1176**, Д.Цолмон **1151**, Б.Ундрах **1145**, Ц.Амарсайхан **1141** удаа **оролцсоноос**;

Танхимын тэргүүн Х.Сонинбаяр **1372**, шүүгч Б.Ундрах **172**, Ц.Амарсайхан **155**, Г.Цагаанцоож **153**, П.Золзаяа **70**, Г.Алтанчимэг **8**, Х.Эрдэнэсүвд **2** хуралдааныг тус тус **даргалж**;

Шүүгч Г.Алтанчимэг **287**, П.Золзаяа **286**, Г.Цагаанцоож **283**, Б.Ундрах **281**, Ц.Амарсайхан **268**, Х.Эрдэнэсүвд **266**, Д.Цолмон **261** хэргийг **илтгэсэн** байна.

**Иргэний хэргийн танхимын шүүгчдийн 2018 оны бүтэн жилийн ажлын ачаалал**



Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **31.5** хувь буюу **607** нэхэмжлэгчийн, **67.1** хувь буюу **1297** хариуцагчийн, **1.2** хувь буюу **23** гуравдагч этгээдийн, **0.2** хувь буюу **5** прокурорын гомдлоор хянан хэлэлцэгджээ.

Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **1932** хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл:

Иргэний хуулиар **1216**,



Хөдөлмөрийн тухай хуулиар **455**,  
Гэр бүлийн тухай хуулиар **60**,  
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар **158**,  
Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар **23**,  
бусад хуулиар **20** хэргийг хянан шийдвэрлэжээ.

Мөн энэ хугацаанд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээс хяналтын журмаар гаргасан гомдолд нийт **1363511069** /тэр бум гурван зуун жаран гурван сая таван зуун арван нэгэн мянга жаран ес/ төгрөгийг улсын тэмдэгтийн хураамжид төлсний **533164367** /таван зуун гучин гурван сая нэг зуун жаран дөрвөн мянга гурван зуун жаран долоо/ төгрөгийг буцаан олгожээ.

Тус танхим **2018** оны бүтэн жилд нийт **78** албан бичиг, **49** өргөдөл, гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн Х.Сонинбаяр **56** албан бичиг, **35** өргөдөл, гомдол, шүүгч Г.Алтанчимэг **2** албан бичиг, **1** өргөдөл, гомдол, Б.Ундрах **2** албан бичиг, **2** өргөдөл, гомдол, Г.Цагаанцоож **5** албан бичиг, **1** өргөдөл, гомдол, Д.Цолмон **1** албан бичиг, **2** өргөдөл, гомдол, Ц.Амарсайхан **5** албан бичиг, **1** өргөдөл, гомдол, П.Золзаяа **2** албан бичиг, **2** өргөдөл, гомдол, Х.Эрдэнэсүвд **1** албан бичиг, **1** өргөдөл, гомдол тус тус хянан шийдвэрлэж, одоо **4** албан бичиг, **4** өргөдөл, гомдлын үлдэгдэлтэй байна.

**Иргэний хэргийн танхим 2018 оны бүтэн жилийн байдлаар Улс төрийн намын бүртгэлийн талаар дараах ажлыг хийжээ. Үүнд:**

- Монгол Ардын хувьсгалт намын дүрмийн болон даргын өөрчлөлтийг 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор;
- Зон Олны намын дүрэмийн өөрчлөлтийг 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 02 дугаар тогтоолоор;
- Монгол Ардын хувьсгалт намын дүрмийн болон даргын өөрчлөлтийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 03 дугаар тогтоолоор;
- Иргэний хөгжил, хүмүүнлэг үйлсийн намыг 2018 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 08 дугаар тогтоолоор;
- Их эв намыг 2018 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор;
- Гэр хороолол хөгжлийн намыг 2018 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор;
- Монгол Ардын Хувьсгалт намын дүрмийн болон даргын өөрчлөлтийг 2018 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 16 дугаар тогтоолоор;



- Бүгд Найрамдах намын дүрмийн болон даргын өөрчлөлтийг 2018 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 17 дугаар тогтоолоор;
- Гэр хороолол хөгжлийн намыг 2018 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 18 дугаар тогтоолоор;
- Монголын Шинэчлэлт намыг 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор;
- Ард түмний олонхийн засаглал намыг 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 22 дугаар тогтоолоор;
- Эрх чөлөөг хэрэгжүүлэгч намыг 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 23 дугаар тогтоолоор тус тус улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж,
- Дэлхийн Монголчууд намыг 2018 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 05 дугаар тогтоолоор;
- Иргэний Зориг Ногоон намын дүрмийн болон даргын өөрчлөлтийг 2018 оны 03 дүгээр сарын 05-ны өдрийн 06 дугаар тогтоолоор;
- Зон Олны намын даргын өөрчлөлтийг 2018 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 12 дугаар тогтоолоор;
- Хөдөлмөрийн Үндэсний намын дүрмийн өөрчлөлтийг 2018 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 13 дугаар тогтоолоор;
- Монгол ардын хувьсгалт намын дүрэм, мөрийн хөтөлбөр, даргын өөрчлөлтийг 2018 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 19 дүгээр тогтоолоор тус тус улсын бүртгэлд бүртгэж шийдвэрлэсэн байна.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний болон шүүгчийн захирамж **2806** гаргаснаас Танхимын тэргүүний “Шүүх бүрэлдэхүүн томилох тухай” **2126**, “Улсын тэмдэгтийн хураамж буцааж олгох тухай” **543**, “Гомдол хэлэлцүүлэхээс татгалзах тухай” **65**, “Гомдол гаргаагүйд тооцох тухай” **72** шүүгчийн захирамж тус тус гарчээ.



# ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ



### 1.3. Захиргааны хэргийн танхим

Захиргааны хэргийн танхим 2017 оны үлдэгдэл 18 хэрэг дээр 2018 онд хяналтын шатны журмаар захиргааны 565 хэрэг, Ерөнхий шүүгчид гомдол гаргасан 90, Шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулах 30, Шүүхийн ёс зүйн хорооны гомдолтой 20, Мэргэжлийн хариуцлагын хорооны гомдолтой 9, Давж заалдах шатны журмаар 8, нийт 740 хэргийг хүлээн авч, 512 хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай 31 хүсэлт, гомдлыг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамжид гомдол гаргасан 27 хэргийг хянан хэлэлцэж, 63 хэргийг хуралдаанд оролцуулахгүйгээр, анхан шатны журмаар ирүүлсэн 2 нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгон, 83 хэрэгт Ерөнхий шүүгчийн ажлын албанаас хариу өгч, одоо 22 хэргийн үлдэгдэлтэй байна.

#### Хяналтын журмаар нийт хүлээн авсан 740 хэргээс





**Захиргааны хэргийн танхимын** хяналтын шатны шүүх хуралдаан нийт **65** өдөр хуралдаж, **өдөрт** дунджаар **7.9** хэрэг хэлэлцжээ.

Захиргааны хэргийн танхимд хяналтын шатны журмаар ирүүлсэн **644** хэргээс нэг шүүгчид **92** хэрэг тус тус ногдож байна.

Хяналтын шатны журмаар хэлэлцэгдсэн **512** хэргийн **66.0** хувь буюу **338** хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, **10.6** хувь буюу **54** хэргийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, **23.4** хувь буюу **120** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгожээ.


Шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон **120** хэргийн **27.5** хувь буюу **33** хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан болон давж заалдах шатны шүүхэд буцааж, **21.7** хувь буюу **26** хэргийн нэхэмжлэлийг болон хэргийг хэрэгсэхгүй болгох, эсхүл нэхэмжлэлийг хангаж, **50.8** хувь буюу **61** хэргийн магадлалыг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчлөлт оруулсан байна.

Шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулсан **54** хэргийн **35.2** хувь буюу **19** хэргийг хууль буруу хэрэглэсэн, **46.3** хувь буюу **25** хэргийг шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй гэсэн үндэслэлүүдээр, **18.5** хувь буюу **10** хэргийн шийдвэр, магадлалд бусад өөрчлөлт оруулсан.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай **32** хэргийн **31** хэргийн хүсэлтийг хангаагүй, **1** хэргийн оролцогч хүсэлтээсээ татгалзсан байна.

Хяналтын журмаар шүүгч Х.Батсүрэн **94**, Л.Атарцэцэг **93**, Г.Банзрагч **92**, Д.Мөнхтуяа **92**, Ч.Тунгалаг **91**, Б.Мөнхтуяа **91**, П.Соёл-Эрдэнэ **91** захиргааны хэрэг тус тус хүлээн авчээ.

Шүүгч тус бүрийн хүлээн авсан хэрэг:





**Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн М.Батсуурь 300, Ч.Тунгалаг 330, Х.Батсүрэн 328, Г.Банзрагч 326, Б.Мөнхтуяа 324, П.Соёл-Эрдэнэ 324, Л.Атарцэцэг 321, Д.Мөнхтуяа 307 удаа тус тус оролцсоноос;**

Танхимын тэргүүн М.Батсуурь 300, Х.Батсүрэн 81, шүүгч Л.Атарцэцэг 68, Ч.Тунгалаг 45, Д.Мөнхтуяа 13, Б.Мөнхтуяа 5 хэргийн шүүх хуралдааныг тус тус даргалж;


Шүүгч П.Соёл-Эрдэнэ 77, Г.Банзрагч 76, Х.Батсүрэн 76, Ч.Тунгалаг 74, Л.Атарцэцэг 73, Б.Мөнхтуяа 70, Д.Мөнхтуяа 66 хэрэг тус тус илтгэсэн байна.

**Гомдлыг хүлээн авахаас татгалзсан захирамж, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлтийг шийдвэрлэх шүүх хуралдаанд Танхимын тэргүүн 16, шүүгч Д.Мөнхтуяа 35, Х.Батсүрэн 33, Г.Банзрагч 33, Ч.Тунгалаг 31, П.Соёл-Эрдэнэ 31, Л.Атарцэцэг 30, Б.Мөнхтуяа 27 удаа тус тус оролцсоноос;**

Танхимын тэргүүн М.Батсуурь 16, Х.Батсүрэн 13, шүүгч Л.Атарцэцэг 11, Ч.Тунгалаг 11, Д.Мөнхтуяа 4, Б.Мөнхтуяа 3 хэргийн шүүх хуралдааныг тус тус даргалж;

Шүүгч Г.Банзрагч 9, Х.Батсүрэн 9, Д.Мөнхтуяа 9, П.Соёл-Эрдэнэ 9, Ч.Тунгалаг 8, Л.Атарцэцэг 7, Б.Мөнхтуяа 7 хэрэг тус тус илтгэсэн байна.

Захиргааны хэргийн танхимын шүүгчдийн  
2018 оны ажлын ачаалал:







Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн нийт **512** хэргийн **21.1** хувь буюу **108** хэргийг нэхэмжлэгчийн, **25.8** хувь буюу **132** хэргийг хариуцагчийн, **7.4** хувь буюу **38** хэргийг гуравдагч этгээдийн, **29.5** хувь буюу **151** хэргийг хэргийн оролцогчдын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн, **15** хувь буюу **77** хэргийг хэргийн оролцогчдын өмгөөлөгчийн, **1.2** хувь буюу **6** хэргийг гомдол гаргагчийн гомдлоор хянан хэлэлцжээ.

Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **512** хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл:

Төрийн албаны маргаан - **147**,

Газрын маргаан - **111**,

Ашигт малтмалын маргаан - **67**,

Татварын маргаан - **36**,

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлтэй холбоотой маргаан - **33**,

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай маргаан - **10**,

Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалтай - **8**,

Сонгуулийн маргаан - **6**,

Бусад маргаан - **94** байна.

Мөн хугацаанд нэхэмжлэгч, гуравдагч этгээдээс хяналтын журмаар гаргасан гомдолд нийт **26,395,200** /Хорин зургаан сая гурван зуун ерэн таван мянга хоёр зуун/ төгрөгийг улсын тэмдэгтийн хураамжид төлсний **9,828,000** /есөн сая найман зуун хорин найман мянган/ төгрөгийг буцаан олгожээ.

Тус танхим **2018** оны бүтэн жилд нийт **50** албан бичиг, **16** өргөдөл, гомдол хүлээн авснаас: Танхимын тэргүүн М.Батсуурь **29** албан бичиг, **10** өргөдөл гомдол, шүүгч П.Соёл-Эрдэнэ **5** албан бичиг, **1** өргөдөл гомдол, шүүгч Г.Банзрагч **4** албан бичиг, **1** өргөдөл гомдол, шүүгч Х.Батсүрэн **3** албан бичиг, **1** өргөдөл гомдол, шүүгч Б.Мөнхтуяа **3** албан бичиг, **1** өргөдөл гомдол, шүүгч Л.Атарцэцэг **3** албан бичиг, шүүгч Д.Мөнхтуяа **1** албан бичиг, **1** өргөдөл гомдол, шүүгч Ч.Тунгалаг **1** албан бичиг, **1** өргөдөл гомдолд хариу өгч, одоо **1** албан бичгийн үлдэгдэлтэй байна.

Тайлангийн хугацаанд нийт **910** шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол гаргаснаас **шүүгчийн захирамжаар 703** /шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай **523**, улсын тэмдэгтийн хураамж буцаан олгох тухай **67**, шүүх хуралдааныг хойшлуулах тухай **55**, гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай **49**, гомдол гаргаагүйд тооцох тухай **8**, нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсныг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох **1**/, **шүүхийн тогтоолоор 207** /шүүх хуралдааныг



хойшлуулах тухай **140**, шинээр илэрсэн нөхцөл байдлын хүсэлтийг шийдвэрлэх тухай **31**, шүүгчийн захирамж хэлэлцсэн тухай **27**, нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсаныг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай **3**, гомдол, хүсэлт гаргаагүйд тооцох тухай **3**, гомдлыг буцаах тухай **2**, хүсэлт хэрэгсэхгүй болгох тухай **1**/ байна.



## ХОЁР. БУСАД АСУУДЛААР

*Улсын Дээд шүүхийн шүүгч нар:*

- “Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай” /шинэчилсэн найруулга/ хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- “Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай” /шинэчилсэн найруулга/;
- “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
- “Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”;
- “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулийн шинэчилсэн найруулга;
- “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”;
- “Монгол Улсын Үндсэн хууль”-д оруулах нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- “Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай” хуулийн төсөлд санал
- “Өмгөөллийн тухай” хууль;
- “Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;
- “Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай” хууль;
- “Хөдөлмөрийн тухай” хуулийн шинэчилсэн найруулга;
- “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга;
- “Хууль зүйн туслалцааны тухай” /шинэчилсэн найруулга/ хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- “Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай” /шинэчилсэн найруулга/ хууль;
- “Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга;
- “Шүүгч сонгон шалгаруулах журам”;
- “Эрүүгийн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”;
- “Эрүүгийн хариуцлага хүлээсэн хүн, хуулийн этгээдийн талаарх мэдээлэл солилцох журам”-ын төслүүдэд тус тус санал өгч, хууль тогтоомжийг боловсронгуй болгох үүргээ хэрэгжүүлжээ.

Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн **Б.Цогт** “Шүүхийн тухай багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах” ажлын хэсгийн гишүүнээр;

“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл”-ийн гишүүнээр;



“Цагаатгах ажлын удирдан зохион байгуулах улсын комисс”-ын гишүүнээр;

Иргэний хэргийн танхимын тэргүүн **Х.Сонинбаяр** “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай” хуулийн шинэчилсэн найруулга, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн ахлагчаар, шүүгч **Ц.Амарсайхан, Б.Ундрах** нар гишүүнээр;

Танхимын тэргүүн **Х.Сонинбаяр** Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/ иргэний хэргийн мониторингийн ажлын хэсгийн ахлагчаар;

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн “Хууль тайлбарлах онол арга зүй” хичээлийн хөтөлбөр, сэдэв боловсруулах ажлын хэсгийн ахлагчаар;

“Шүүх эрх мэдэл” мэдээлэл, арга зүйн улирал тутмын эмхтгэлийн редакцын зөвлөлийн гишүүнээр;

Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь** “Захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системийг зүгшрүүлэх” ажлын хэсгийн ахлагчаар;

“Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсгийн гишүүнээр;

“Захиргааны ерөнхий хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсгийн гишүүнээр;

“Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн ажлын хэсгийн гишүүнээр;

“Нотариатын тухай” хуулийн ажлын хэсгийн гишүүнээр;

“Хуульч, эдийн засагчийн нэгдсэн клуб”-ын гишүүнээр;

“Хэргийн хөдөлгөөний удирдлага, бодлого зохицуулалтын чиглэлээр шүүхийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах дэд ажлын хэсгийн гишүүнээр;

“Шүүх эрх мэдэл” сэтгүүлийн гишүүнээр;

“Өмгөөлөл” сэтгүүлийн редакцын гишүүнээр;

Шүүхийн мэргэшлийн хорооны гишүүнээр;

Нотариатын мэргэшлийн хорооны гишүүнээр;

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2018 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Шүүхийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг”-ийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр;

“Төрийн албаны тухай хууль” дагасан хуулийг хэрэгжүүлэх албаны ажлын хэсгийн гишүүнээр,

шүүгч **Г.Алтанчимэг** “Арбитрын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын ажлын хэсгийн гишүүнээр;



шүүгч **Ц.Амарсайхан** “Гэр бүлийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль”-ийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр;

шүүгч **Г.Банзрагч** “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах” хууль, Сонгомол шүүхийн шийдвэрийг шалгаруулах ажлын хэсгийн”, “Хуульчийн шалгалтыг дүгнэх ажлын хэсэг”-ийн гишүүнээр;

шүүгч **Х.Батсүрэн** “Монголын шүүгчдийн холбоо”-ны тэргүүнээр;

шүүгч **Д.Ганзориг** “Монгол улсад цаазаар авах ялыг сэргээх талаарх хууль”, “Үндсэн хуулийн цэцийн тухай” хуулиудийн ажлын хэсгийн гишүүнээр;

шүүгч **П.Золзаяа** “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр, Монголын Хуульчдын холбооны дэргэдэх мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүнээр, Нотариатчдын танхимын гишүүнээр;

шүүгч **Б.Батцэрэн, Ч.Хосбаяр** нар “Эрүүгийн хууль”, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай”, “Зөрчлийн хууль”, “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах” ажлын хэсгийн гишүүнээр;

шүүгч **Б.Батцэрэн** “Эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн системийг хэрэгжүүлэх” ажлын хэсгийн ахлагчаар, шүүгч **Ч.Хосбаяр** гишүүнээр, шүүгчийн туслах-шинжээч **Г.Ууганбаатар** ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар;

шүүгч **Д.Мөнхтуяа** Шүүгчдийн холбооны Улсын Дээд шүүхийн салбар зөвлөлийн гишүүнээр;

шүүгч **Ч.Тунгалаг** “Монголын төр, эрх зүй” сэтгүүлийн зөвлөлийн гишүүнээр;

шүүгч **Д.Эрдэнэбалсүрэн** “Цагаатгалын тухай”, “Өмгөөллийн тухай”, “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулиудын ажлын хэсгийн гишүүнээр, “Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл”-ийн гишүүнээр, “Монголын Хуульчдын холбооны удирдах зөвлөл”-ийн гишүүнээр, УИХ-ын гишүүн **О.Батнасан** нарын санаачилсан “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах” ажлын хэсгийн гишүүнээр;

шүүгч **Б.Батцэрэн, Д.Мөнхтуяа** нар Шүүхийн мэргэшлийн хорооны гишүүнээр тус тус ажиллажээ.

Эрүүгийн хэргийн танхимаас 2018 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн 01 дугаартай “Шийтгэх (цагаатгах) тогтоол үйлдэхэд анхаарах зарим асуудлын тухай”, 2018 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн 02 дугаартай “Магадлал үйлдэхэд анхаарвал зохих зарим асуудлын талаар” зөвлөмж гаргаж, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг



боловсруулж, УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлжээ.

Шүүгч **Ц.Амарсайхан** “Шүүгч нарын бодлогын гарын авлага”, “Бусдын эзэмшил ашиглалтад хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон гэрээний эрх зүйн харилцаа” сэдэвт GIZ-ийн номыг эмхэтгэжээ.

Түүнчлэн шүүгч **Г.Банзрагч** Төрийн албан хаагчийн ширээн ном II-ын Дөрөвдүгээр бүлгийг, Шударга ёсны хэмжүүр сэтгүүлд “Захиргааны хэргийн шүүхэд гаргах нэхэмжлэлийн төрөл, шаардлага, тэдгээрт тавигдах урьдчилсан нөхцлүүд” сэдэвт;

Шүүгч **Д.Мөнхтуяа** “Шударга ёсны хэмжүүр сэтгүүл”-ийн 07 дугаар сарын дугаарт “Олон талаас нь судлах, өөр өөр өнцгөөс мэтгэлцэх нь зөв” сэдэвт;

Шүүгч **Ч.Хосбаяр** “Шүүх эрх мэдэл” мэдээлэл арга зүйн улирал тутмын эмхтгэл, 2018 он, дугаар №01-д “Олон улсын эрх зүйн эх сурвалжид хандах нь” сэдэвт өгүүлэл, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн “Эрх зүй” онол, практик, арга зүйн мэргэжлийн улирал тутмын сэтгүүл, 2018 он, дугаар №04-д “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэг ба авлигын эсрэг олон улсын конвенцууд дахь түүний агуулга” сэдэвт өгүүлэл, нийтлэл тус тус хэвлүүлжээ.

Шүүгч **П.Золзаяа** “Худалдах-худалдан авах гэрээ” сэдвээр зөвлөмж гаргаж, 2018 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулийн холбогдох заалтууд Үндсэн хууль зөрчсөн талаарх асуудлаар Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар бэлтгэн оруулжээ.

Иргэний хэргийн танхимын тэргүүн **Х.Сонинбаяр**, шүүгч **П.Золзаяа** нар 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5, 73 дугаар зүйлийн 73.3 дах зүйл заалтууд үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар;

Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь**, шүүгч **Г.Банзрагч** нар 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1, 2 дугаар зүйлийн зарим хэсэг, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн зарим хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох хэсгийг тус тус зөрчсөн эсэх асуудлаар итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр тус тус оролцлоо.



# ТАМГЫН ГАЗАР





## ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН 2018 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

### 3.1. Шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах чиглэлээр:

Тамгын газар нь Шүүхийн тухай багц хууль, Төрийн албаны тухай, Төсвийн тухай, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль, тэдгээрт нийцүүлэн гарсан дүрэм, журам, заавар, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх, нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хугацаанд нь хийж гүйцэтгэх, Шүүхийн захиргааны тухай хуулийн **6-12** дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх талаар анхааран ажиллаж иржээ.

**Авлигын эсрэг хууль, “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-д** заасны дагуу шүүгч, захиргааны албан хаагчдаас **“Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийг 2017 оны байдлаар** шинэчлэгдсэн маягыг дахин гаргуулан авч, **23** шүүгчийн материалыг Шүүхийн Ерөнхий зөвлөлийн Сахилгын хороонд, захиргааны албан хаагч **62** хүний материалыг Тамгын газарт зохих журмын дагуу хадгалж, цахим хэлбэрээр шинэчлэн гаргажээ.

Мөн захиргааны албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн **9** хүний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг **“Авлигатай тэмцэх газар”-т** хянуулахаар хүргүүлэн холбогдох зөвшөөрлийг авч, томилон ажиллуулжээ.

Түүнчлэн **“Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан”-г** шинэчилсэн програмын дагуу гаргаж, Төрийн албаны зөвлөлд тогтсон хугацаанд нь хүргүүлсэн байна.

Тамгын газрын дарга хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн нийт **158** тушаал гаргасан байна.

**“Билгийн тооллын хаврын тэргүүн сар-Цагаан сарын баяр”, “Хүүхдийн баяр”** бусад тэмдэглэлт баяр, бүх нийтийн амралтын өдрүүдэд тухай бүр арга хэмжээг зохион байгуулж, Улсын Дээд шүүх дээр сахилга, хариуцлага, дэг журам, сонор сэрэмжийг өндөржүүлэх зорилгоор Тамгын газрын даргын **7** удаагийн тушаалаар **14** ажилтныг хариуцлагатай эргүүлээр томилон ажиллуулжээ.

Мөн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д “Хуульч хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсны дараа



шүүхэд төлөөлөх эрх нээлгэхээр Улсын Дээд шүүхэд бүртгүүлж ... өмгөөлөгчийн нэрсийн жагсаалтад бүртгэгдэнэ” гэж заасны дагуу Тамгын газрын даргын тушаалаар энэ онд **170**, нийт **2810** хуульчдад өмгөөлөгчийн шүүхэд төлөөлөх эрхийг тус тус нээж, гэрчилгээ, үнэмлэх олгоод байна.

Тайлангийн хугацаанд **408** өргөдөл гомдол, **1083** албан бичиг, **3895** хавтаст хэрэг хүлээн авч, зохих журмын дагуу бүртгэн, бүртгэл хяналтын карт нээж, уг албан бичгүүдийг Ерөнхий шүүгч, Тамгын газрын даргад танилцуулсны дагуу шүүгч, ажилтнуудад хуваарилан өгч шийдвэрлүүлснээс гадна **4901** албан бичигт дугаар өгч холбогдох шүүх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад явуулжээ.

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч **Ц.Зориг**, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн **Б.Цогт**, Иргэний хэргийн танхимын тэргүүн **Х.Сонинбаяр**, Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь** нар тус шүүхэд ажиллаж байгаад гавъяаныхаа амралтад гарсан ахмадуудаа 2018 оны 2 дугаар сарын 06-ны өдөр, 2018 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр тус тус хүлээн авч, хүндэтгэл үзүүллээ.



Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2017 оны 5 дугаар сарын 29-ний өдөр 1/4552 дугаартай хамтран ажиллах тухай албан бичгийг ирүүлсний дагуу Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Засгийн газрын 2013 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан **“Төрийн байгууллагуудын цахим мэдээллийн санг ашиглах журам”**-ыг тус тус үндэслэн төрийн байгууллага хоорондын ажлын уялдааг хангаж, хамтын ажиллагааг өргөжүүлэх, мэдээллийг цахим хэлбэрээр солилцож үйл ажиллагаандаа ашиглах, төрийн үйлчилгээг хялбаршуулах зорилгоор Улсын Дээд шүүх болон Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газар хооронд 2017 оны 6 дугаар сарын 05-ны өдөр **“Мэдээлэл солилцох гэрээ”** байгуулсан билээ.

Тус ажлын хүрээнд Үндэсний дата төвтэй 2018 оны 02 дугаар сард шинээр гэрээ байгуулж ХУР-ын системийн ашиглах эрх үүсч, Онлайнсоюшинс ХХК нь 2018



оны 11 дүгээр сард програм хангамжийг Улсын Дээд шүүхэд суурилуулах, турших ажлыг хийж гүйцэтгэж байна.



Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 25 жилийн ойд зориулсан спортын тэмцээнд Улсын Дээд шүүхийн баг тамирчид амжилттай оролцжээ.



Улсын Дээд шүүхээс анхан болон давж заалдах шатны шүүхүүдийн дунд хөлбөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2018 оны 9 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд нийт 20 шүүхийн баг тамирчид өрсөлдсөнөөс А.Эрдэнэт ахлагчтай Улсын Дээд шүүхийн баг тамирчид алтан медаль, аваргын цом хүртжээ.





Мөн хуулийн төв байгууллагуудын хооронд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг шилжин явах цомын төлөөх спортын тэмцээнийг Монголын Өмгөөлөгчийн холбоо 2018 оны 11 дүгээр сарын 17, 23-25-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тэмцээнд нийт 11 шүүхийн баг тамирчид өрсөлдөж, А.Эрдэнэт ахлагчтай Улсын Дээд шүүхийн баг тамирчид алтан медаль, аваргын цомын эзэн боллоо.





### 3.2. Шүүхийн хүний нөөцийн чиглэлээр:

Тамгын газрын даргын тушаалаар тэтгэвэр тогтоолгох насны дээд хязгаарт хүрсэн **С.Нямжавыг** Ерөнхий шүүгчийн ажлын албаны Гэмт хэргийн шүүн таслах ажиллагаа хариуцсан зөвлөхийн;

тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн **Ш.Даваадуламыг** Эрх зүйн онол, арга зүйн асуудал хариуцсан референтийн албан тушаалаас тус тус чөлөөлжээ.

Тайлангийн хугацаанд **Ц.Сумъяаг** Захиргааны хэргийн шүүн таслах ажиллагаа хариуцсан зөвлөхийн, **Т.Батдорж**, **М.Ганзориг**, **Г.Хэрлэнчимэг** нарыг Шүүгчийн туслах-шинжээчийн, **Б.Алтансувдыг** Гэмт хэргийн тухай хууль тогтоомж, практик ажил хариуцсан шинжээчийн, **Ч.Батнямыг** Иргэний хэргийн хууль тогтоомж, практик ажил хариуцсан шинжээчийн, **Б.Хүрэлтулгыг** Захиргааны хэргийн хууль тогтоомж, практик ажил хариуцсан шинжээчийн, **М.Билгүтэй**, **Ө.Болорчимэг**, **У.Батцэцэг**, **Д.Мөнхцэцэг**, **Г.Наранхүү**, **Ц.Ундрал** нарыг шүүх хуралдааны нарийн бичгийн дарга-мэргэжилтний албан тушаалд, **Г.Баянмөнх**, **Э.Бишрэл**, **Г.Өлзийбадрах** нарыг жолоочийн, **Г.Ариунаа**, **Б.Өлзийжаргал**, **Б.Шинэбаяр** нарыг үйлчлэгчийн ажилд Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн тус тус томилж, өөрийн хүсэлтээр төрийн албанаас 13 ажилтан чөлөөлөгдсөн байна.

Мөн Тамгын газрын даргын тушаалаар иргэний хэргийн хууль тогтоомж, практик ажил хариуцсан шинжээч **Н.Мөнгөнцэцэгийг** Эрх зүйн онол, арга зүйн асуудал хариуцсан референтийн, **Э.Энхжаргалыг** Эрүүгийн хэргийн танхимын тэргүүний туслах-Ахлах шинжээчийн, Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга-мэргэжилтэн **А.Батдэлгэр**, **Ө.Болорчимэг**, **Э.Боролдой**, **Г.Гантогтох**, **Ш.Мөнхжаргал**, **Г.Наранхүү**, **Ц.Ундрал** нарыг Шүүгчийн туслах-шинжээчийн, **Б.Бадмарагыг** Цагаатгалын ажил хариуцсан шинжээчийн, **Б.Төгөлдөрийг** Шүүн таслах ажиллагааны аюулгүй байдал хариуцсан шинжээчийн албан тушаалд томилон дэвшүүлэн ажиллуулжээ.

#### Тайлангийн хугацаанд:

Компьютерын техник хангамжийн ажил хариуцсан ахлах шинжээч **Ж.Эрдэнэ**, Тамгын газрын туслах-шинжээч **А.Эрдэнэт**, Дотоод ажил хариуцсан шинжээч **Б.Дүүрэнжаргал**, Шүүгчийн туслах-шинжээч **Ч.Батням**, **Г.Ууганбаатар**, **Б.Хүрэлтулга**, Хууль тогтоомжийн системчлэл хариуцсан ахлах мэргэжилтэн



**Б.Марал-Эрдэнэ** нарын төрийн албан хаасан хугацааны нэмэгдлийг шинээр буюу нэмэгдүүлэн,

Бичиг хүргэгч **Б.Уртнасан**, үйлчлэгч **Л.Отгонсүрэнгийн** ур чадварын нэмэгдлийг олгосон байна.

Түүнчлэн Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр “Журам батлах тухай” тогтоолын дагуу шинэчилсэн загвараар **66** хүний үр дүнгийн гэрээг дүгнэх, **21** хүний хөдөлмөрийн гэрээг байгуулах ажлыг хагас, бүтэн жилээр зохион байгуулжээ.

### 3.3. Шүүхийн практик судлах чиглэлээр:

Шүүхийн практик судлах хэлтэс нь 2018 онд шүүхийн практикийг судлах, хууль тогтоомжид санал өгөх, хууль тогтоомжийн системчлэлийн ажлын хийж гүйцэтгэх, ном тохимол, сэтгүүл гаргах чиглэлээр төлөвлөсөн цаг хугацаанд нь бүрэн хийж гүйцэтгэлээ.

Тус хэлтэс нь 2018 онд эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүхийн практикийг судалж, дараах судалгааг хийж гүйцэтгэсэн байна.

***Эрүүгийн хэргийн талаарх шүүхийн практикийг судлах ажлын хүрээнд:***

1. Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар 2017 онд хянагдсан эрүүгийн хэргийн өөрчлөгдсөн, хүчингүй болгосон тогтоол, магадлалын алдаа зөрчлийн тойм;
2. Гадаадын зарим орнуудын гэмт хэргийн улмаас учирсан эрүүл мэнд амь насны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөрийн тогтолцооны судалгаа;
3. Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхтэй холбоотой алдаа зөрчлийн судалгаа;
4. БНСУ-ын Дээд шүүх, АНУ-ын Холбооны Дээд шүүх анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтын талаарх судалгаа;
5. ОХУ-ын Эрүүгийн хууль дахь давтан гэмт хэрэг болон өмчийн эсрэг гэмт хэргийн зохицуулалтын талаарх судалгаа;
6. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр түдгэлзүүлсэн, хэрэгсэхгүй болгосон хэргийн судалгаа /2017 оны 6 сараас 2018 оны 6 сар хүртэл/;
7. Хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж шүүгчийн захирамжаар буцаасан хэргийн судалгаа /2018 оны 1-10.08-ны өдөр/;



8. Анхан шатны шүүхээс Эрүүгийн хуулийн 10.1, 11.1, 12.1, 27.10 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шийдвэрлэлт, ял оногдуулсан байдлын талаарх судалгаа;
9. Хорих ялын доод хэмжээ таван жил болон түүнээс дээш, хорих ялын доод хэмжээг найман жил түүнээс доош хэмжээгээр тогтоосон гэмт хэргийн судалгаа;
10. Мөрдөн байцаалтад буцааж шийдвэрлэсэн хэргийн судалгаа /2013-2018 оны хагас жил/;
11. Эрүүгийн хуулийн 18.5 дугаар зүйл /Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх/-ээр шийдвэрлэсэн хэргийн судалгаа /2012 - 2017 он/;
12. Эрүүгийн хуулийн 19.14 дүгээр зүйл /Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх/-ээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн судалгаа;
13. Улсын Дээд шүүхээс шүүн таслах ажиллагааны практик судлах, анхан болон давж заалдах шатны шүүгч нартай хийх уулзалт ярилцлагын хүрээнд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар шийдвэрлэсэн хэргийн багц судалгаа /шүүх тус бүрээр/;
14. Хяналтын шатны шүүхээс давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулсан хорих ялыг хэвээр үлдээсэн хэргийн судалгаа /2017-2018.9.10/;
15. Шүүхээр хянан шийдвэрлэсэн үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн судалгаа /2013-2018 оны хагас жил/;
16. Эрүүгийн хуулийн 110, 111 дүгээр зүйлүүдээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн судалгаа;
17. Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг болон зөрчлийн талаарх судалгаа;
18. Цагдан хоригдсон этгээдтэй уулзах зөвшөөрлийн бичиг олгож байгаа байдлын талаарх судалгааг тус тус хийж гүйцэтгэсэн байна.

***Иргэний хэргийн талаарх шүүхийн практикийг судлах ажлын хүрээнд:***

1. Анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхээр 2016, 2017 онд хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тойм;
2. Анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч нарт зориулсан уулзалтанд зориулж улсын хэмжээнд анхан, давах, хяналтын шатны шүүх хуралдаанаар 2017 онд нийт шийдвэрлэсэн иргэний хэргийн судалгаа болон хяналтын шатны шүүх хуралдаанаас шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулсан, хүчингүй болгосон иргэний хэргийн тоймыг шүүх тус бүрээр;





3. Хяналтын шатны шүүх хуралдаанаас 2017 онд магадлалыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээсэн, өөрчлөлт оруулсан хэргийн судалгаа;

4. Хяналтын шатны шүүх хуралдаанаас 2017 онд шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан болон давж заалдах шатны шүүхэд буцаасан хэргийн судалгаа;

5. Хяналтын шатны шүүх хуралдаанаас 2017, 2018 оны 1 дүгээр улиралд магадлалыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээсэн, өөрчлөлт оруулсан хэргийн харьцуулсан судалгаа;

6. Хяналтын шатны шүүх хуралдаанаас 2017, 2018 оны 1 дүгээр улиралд шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан болон давж заалдах шатны шүүхэд буцаасан хэргийн харьцуулсан судалгаа;

7. Шүүхийн Ерөнхий зөвлөлийн захиалгаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн гэх үндэслэлээр Улсын Дээд шүүхийн иргэний хэргийн шүүх хуралдаанаар шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан, давж заалдах шатны шүүхэд 2015-2017 онд буцаасан иргэний хэргийн судалгаа;

8. 2017 онд иргэний хэргийг хянан шийдвэрлэх хуулийн хугацаа хэтэрсэн хэргийн судалгаа;

9. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд гомдол гаргаж, 2016, 2017 онд хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн судалгаа;

10. Гэр бүлийн тухай хуулиар /2014-2016 он/ хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн судалгаа;

11. Даатгалын гэрээтэй холбоотой 2017 онд шүүхээр хянан шийдвэрлэсэн хэргийн судалгаа;

12. Иргэний хэргийн танхимын шүүгчийн ажлын ачааллыг /2015-2017 он/ судалж, ачааллыг бууруулах тухай бодлогын судалгааг тус тус хийж гүйцэтгэсэн байна.

***Захиргааны хэргийн талаарх шүүхийн практикийг судлах ажлын хүрээнд:***

1. Хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн буюу иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу тогтоол, магадлалыг Улсын Дээд шүүхээс хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцаасан талаарх судалгаа /2015 он/;



2. Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоолын шинэчилсэн загвар боловсруулахтай холбогдсон олон улсын болон дэлхийн улс орнуудын шүүхийн шийдвэрийн загварын харьцуулсан судалгаа;
3. Захиргааны хэргийн анхан, давж заалдах шатны шүүхүүдийн 2017 оны шийдвэрийн тогтвортой байдлын судалгаа;
4. Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар 2017 онд хянагдсан захиргааны хэргийн дүн, өөрчлөгдсөн, хүчингүй болсон шийдвэр, магадлалыг судалсан тухай тойм;
5. Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар хэрэг хянан хэлэлцэж шийдвэр гаргахдаа захиргааны ерөнхий хуулийг хэрэглэсэн байдлын судалгаа /2017 оны ХШЗХШХ-аар шийдвэрлэсэн хэрэг/;
6. Захиргааны хэргийн шүүх хуралдаанаар төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв байгууллага хариуцагчаар оролцсон маргааны судалгаа;
7. Үндсэн хуулийн цэцээс ирүүлсэн албан бичигтэй холбогдсон эрх зүйн шийдлийн судалгаа;
8. Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар байгаль орчныг хамгаалах хуулиудыг хэрэглэж шийдвэрлэсэн маргааны судалгаа /2016-2017 оны ХШЗХШХ-аар шийдвэрлэсэн хэрэг/;
9. “Олон улсын хуульчдыг байгаль орчныг хамгаалахад гүйцэтгэх үүрэг, чиг хандлага, шаардлагатай мэдлэгийн түвшин” илтгэлийн танилцуулгад хэрэглэгдэх холбогдох баримт бичгийн багц судалгаа;
10. Дэлхийн улс орнуудын сонгуулийн маргаан шүүхэд хянан шийдвэрлэх процессын харьцуулсан судалгаа /сонгуулийн тухай хуулийн ажлын хэсэгт зориулсан/;
11. Дэлхийн зарим улс орнуудын төрийн өндөр албан тушаалтнуудын цалин ба цалингийн түвшинг харьцуулалт;
12. 2017-2018 онд УДШ-ийн ХШЗХШХ-аар хянан шийдвэрлэгдсэн төрийн албан хаагчийн хөдөлмөрлөх эрхийн зөрчлийг тогтоож, учирсан хохирлыг арилгахтай холбогдсон шүүхийн шийдвэрүүдийн тогтоолд хийсэн судалгаа/*ТАТХ-ийн 27.2.3,4/*;
13. Захиргааны хэргийн анхан, давж заалдах шатны шүүхүүдийн 2017-2018 оны эхний хагас жилийн шийдвэрийн тогтвортой байдлын судалгаа /2017.01-2018.06/;
14. Шүүгчийн аюулгүй байдлын судалгаа;



15. Дэлхийн улс орнуудын шүүх эрх мэдлийн ҮХ-ийн эрх зүйн харьцуулсан судалгааг /Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөд Улсын Дээд шүүхээс өгөх саналд зориулсан/ тус тус хийж гүйцэтгэсэн байна.

### ***Хоёр. Хууль тогтоомжийн системчлэлийн ажлын талаар***

2018 онд төлөвлөгдсөн ажлууд хийгдэж байна. Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их хурлын Тамгын газраас манайд ирүүлж байгаа Монгол Улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их хурлын тогтоол, Үндсэн хуулийн цэцийн тогтоол, дүгнэлт, “Төрийн мэдээлэл” сэтгүүлүүдийг дугаар бүрээр нь хүлээн авч шүүгч, ажилтнуудад эх хувиар болон дотоод сүлжээгээр дамжуулан ашиглуулж, лавлагаа өгч, шүүхийн мэдээллийн санг баяжуулан ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд нэгдсэн санд:

- Монгол Улсын хууль **122**,
- Улсын их хурлын тогтоол **75**,
- Ерөнхийлөгчийн зарлиг **13**,
- Төрийн мэдээлэл сэтгүүлийн **42** дугаар,
- Үндсэн хуулийн цэцийн тогтоол **4**, дүгнэлт **11**-ийг хүлээн авч, оруулсан байна.

### ***Гурав. Ном тохимол, сэтгүүл, эрдэм шинжилгээний хурлын талаар:***

1. Монголын төр эрх зүй” сэтгүүлийн 2017 оны 4, 2018 оны 1, 2, 3 дугаар улирлын дугаарыг эрхлэн гаргалаа.

2. Дэлхийн улс орнуудын Дээд шүүхийн танилцуулга бүтээлийн эх материалыг орчуулах болон бусад эх сурвалжуудаас бэлтгэх ажлыг гүйцэтгэж байна.

### ***Дөрөв. Бусад ажлын талаар***

1. Улсын Дээд шүүхийн шүүх хуралдааны тогтоолын өгөгдлийн санд 2018 оны тогтоолуудыг нэг бүрчлэн судалж, үзүүлэлтийг түүвэрлэн оруулж байна.

2. Шүүхийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсгийн захиалгаар гадаад орнуудын шүүх эрх мэдлийн харьцуулсан судалгааг хийж гүйцэтгэв.

## **3.4. Шүүхийн санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр:**

Улсын Дээд шүүхийн 2018 оны жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу тус хэлтэс нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланг холбогдох байгууллагуудад хуулийн хугацаанд хүргүүлэх, санал дүгнэлт гаргуулах, төсвийн төлөвлөлтийг оновчтой зөв тооцон боловсруулах, батлуулах, хуваарилах,



батлагдсан төсвийг хууль, тогтоомжийн дагуу зөв зохистой зарцуулах, төсөв санхүү болон бусад холбогдох хууль тогтоомж, түүний хэрэгжилтийг хангах, шүүхийн санхүүгийн үйл ажиллагааг хөтлөх зэрэг үндсэн чиг үүргийн ажлуудыг бүрэн хэрэгжүүлэн ажиллалаа.

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулиар Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн багц **3.9** тэрбум төгрөгөөр батлагдсан бөгөөд 2018 онд нийтдээ улсын төвлөрсөн төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилтээр **3.9** тэрбум төгрөг авахаас **3.9** тэрбум төгрөгийн санхүүжилт авч **3.7** тэрбум төгрөгийг зарлага гаргаж, 92%-ийн төсвийн гүйцэтгэлтэй гарахаар төлөвлөгдөж байна.

Улсын Дээд шүүхийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гарган тайлагнаж, аудит хийлгэх, Монгол Улсын нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгтгүүлэхээр Үндэсний Аудитын газар, Сангийн яамны Төрийн сангийн газруудад тус тус хүргүүлж, тайлагнаж, үнэн зөв нэгтгүүллээ.

Дээрх тайланд Үндэсний Аудитын газраас “Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн гэж “**Зөрчилгүй**” санал дүгнэлт гаргаж, бидний ажлыг дүгнэсэн байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх хэсэгт заасны дагуу дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан Улсын Дээд шүүхийн 2019 оны урсгал төсвийг **6.8** тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын төсвийг **21.6** тэрбум төгрөг буюу нийт **28.4** тэрбум төгрөгөөр төлөвлөж, хязгаарын саналыг боловсруулж, хянуулснаар холбогдох газруудад тус тус хүргүүлэн нэгтгүүлж, хянууллаа.

Шүүхийн 2018 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хяналтын шатны шүүхийн хэвийн ажиллагааг хангахад зарцуулсан бөгөөд шүүгч, албан хаагчдын дунд сургалт, уулзалт семинар зохион байгуулах, зочин төлөөлөгч хүлээн авах, гадаад болон дотоодод томилолтоор ажиллах, захиргааны ажилтан, албан хаагчдыг гадаадын шүүхүүдтэй танилцах сургалтын хөтөлбөр зэрэг үйл ажиллагааны зардалд **303.9** сая төгрөг, шүүхийн ахмад ажилчдыг хүлээн авах, түлээ нүүрсний хөнгөлөлт олгох, дэмжлэг тусламж үзүүлэх болон шагнал, мөнгөн урамшуулал, тэтгэмжийн зардалд **25.2** сая төгрөг,



тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардалд **26.3** сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны нийтлэг журмын 7.1.3-т “**шүүгч, ажилтныг шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах**” гэж заасны дагуу батлагдсан төсвийн хүрээнд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зохих зөвшөөрөл авснаар **284.3** сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж авч үндсэн болон эргэлтийн хөрөнгөнд бүртгэж, ашиглалтад хүлээлгэн өгсөн байна.

Шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах, хяналтын шатны шүүн таслах ажлыг таниулах, сурталчлах, хэргийн оролцогч, иргэд, хуулийн этгээдэд түргэн шуурхай мэдээлэл хүргэх мэдээлэл сурталчилгааны ажил, вирусны програм суулгах, цахим сүлжээний хэрэглээ болон програм хангамжийн сайжруулалт зэрэг ажлуудыг **42.7** сая төгрөгөөр, хяналтын шатны шүүхийн 2018 оны тайлан хэвлүүлэх, ном сонин захиалах, худалдан авах зэрэг ажлуудыг **5.1** сая төгрөгөөр тус тус санхүүжүүллээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 71, 72, 73 дугаар зүйлд заасны дагуу “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн тооллого” болохтой холбогдуулан Тамгын газрын даргын 2018 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн А/20, 2018 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/52 дугаар тушаалаар тус тус хөрөнгийн тооллого зохион байгуулах, хэрэгжүүлэх комисс байгуулагдан хагас, бүтэн жилийн хөрөнгийн тооллогыг хийж, нэгдсэн дүнг тайлагнаж, “Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн мэдээллийн систем”-ийн програм хангамжид Улсын Дээд шүүхийн 2017 оны жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдэл, холбогдох мэдээллийг цаг хугацаанд нь багтаан оруулж ажиллалаа.

Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх, Давж заалдах шатны шүүхүүдийн байрыг балансаас балансад шилжүүлэхээр МУ-ын Засгийн газрын 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 69 дүгээр тогтоол гарсантай холбогдуулан өмчийг бүрэн шилжүүлж, хөрөнгөнд бүртгэлд тусгаж, холбогдох тооцоог хийлээ.

Хөрөнгийн үнэлгээг дахин хийхтэй холбогдуулан Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 273 дугаар тогтоол гарсны дагуу хөрөнгийн үнэлгээг дахин хийхээр Тамгын газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 13-ний өдрийн А/50 тоот тушаалын дагуу ажлын хэсэг байгуулагдсанаар үнэлгээг дахин хийж холбогдох арга хэмжээг авч, ажлыг хэрэгжүүлж байна.



Түүнчлэн 2018 оны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хэрэгжилтийн хүрээнд шилжиж ирсэн байранд шинээр шүүх хуралдааны 2 танхимыг засварлан тохижуулахын тулд нээлттэй тендер шалгаруулалтын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу зохион байгуулан хэрэгжүүлж, **250.1** сая төгрөгийн засварын ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.



Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүднээс “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу тендерийг удаа дараа зохион байгуулснаар урсгал төсвийн тооцоонд давхардсан дүнгээр харьцуулалтын





аргаар 14 үйл ажиллагааны нийт 195.3 сая төгрөгийн, нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 2 ажиллагааны 182.0 сая төгрөгийн ажлуудыг сонгон шалгаруулж, хийж гүйцэтгүүлжээ.



Улсын Дээд шүүхийн байрны халаалтын дундын шугамын зарим хэсэг буюу 36м шугамыг шинэчлэх, халаалтын бойлерын удирдлагын хуваарилагч солих, зарим өрөөнүүдийн пар солих, өрөө тасалгаа, дээврийн засвар зэрэг жижиг засварын ажлуудыг өөрсдийн дотоод нөөцөд тулгуурлаж хийж, гүйцэтгэсэн бөгөөд балансаас балансад шилжиж ирсэн байрны ашиглалтыг сайжруулах засвар үйлчилгээг зохих түвшинд бүрэн хийж дуусгасан байна.



Мөн авто тээврийн хэрэгслүүдийн хэвийн ажиллагааг хангах, даатгал, оношлогоо, газрын хураамж болон шүүгч нарын эрүүл мэндийн даатгал, бусад төлбөр хураамж, хог хаягдлын зардалд **74.1** сая төгрөгийг зарцуулсан байна.

Шүүгч ажилтнуудыг шаардлагатай бичиг хэрэг, хангамжийн материалаар хангах, шүүгчийн туслах, нарийн бичгийн дарга нар, мэдээлэл лавлагааны ажилтан зэрэг олон нийттэй харилцах ажилтнуудыг албаны хувцсаар жигдлэх, бусад бараа үйлчилгээ, шатахууны зардалд **153.1** сая төгрөг, байр ашиглалтын зардалд **71.3** сая төгрөг, цалин болон нийгмийн даатгалын шимтгэлд **2622.2** сая төгрөгийн зарлага гаргаснаар 2018 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг батлагдсан төсвийн хэмжээнд бүрэн санхүүжүүлж, дэмжин ажилласан билээ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) болон Улсын Дээд шүүхийн сайт дахь Төсвийн ерөнхийлөн





захирагчийн 2018 оны батлагдсан төсөв, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, бүтэн жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш хэмжээтэй зардал зэрэг холбогдох шаардлагатай мэдээ, мэдээллүүдийг цаг тухай бүрт нь хуулийн хугацаанд оруулах, шүүхийн 2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг e-procurement.mn сайт дээр байршуулах зэргээс гадна холбогдох тайлан, төсвийн гүйцэтгэлийн мэдээг хуулийн хугацаанд гарган тайлагнаж, Сангийн яам болон бусад газруудад хүргүүлэн ажилласан байна.

### 3.5. Шүүхийн зохион байгуулалтын чиглэлээр:

Тус хэлтэс нь шүүн таслах ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулах нөхцөлийг хангах ажлыг зохион байгуулан, шүүх хуралдааны танхим, техник, зохион байгуулалтын бэлтгэлийг хангах, хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол, шүүгчийн захирамжийн төсөл боловсруулах, ёсчлуулах, тэдгээрийг [www.shuukh.mn](http://www.shuukh.mn) болон [www.supremecourt.mn](http://www.supremecourt.mn) цахим хуудсанд байршуулах, шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөх, ёсчлуулах, шүүх хуралдааныг дуу болон дүрс бичлэгээр баталгаажуулах, шүүн таслах ажиллагааны 2018 оны хагас, бүтэн жилийн тайлан мэдээ гаргах ажлыг зохион байгуулан, хуульд заасан бусад чиг үүргийг гүйцэтгэжээ.

Танхимын тэргүүний туслах, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарын ажлын зохион байгуулалт, хэргийн хөдөлгөөний аргачлал, албан хэрэг хөтлөлт, цахим санд шүүхийн шийдвэр нийтлэх журмын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

2018 онд Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэгдсэн тогтоолыг [www.shuukh.mn](http://www.shuukh.mn) сайтад бүрэн байршуулсан.

Мөн Улсын Дээд шүүхийн вэб сайтад “хяналтын шатны шүүх хуралдааны зар, тойм, статистик мэдээ”-г тус тус тогтмол байршуулж байна.

Тайлангийн хугацаанд Цагдаагийн байгууллагаас шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангаж шүүх хуралдааны журам сахиулан ажиллах хугацаанд Б.Батдэлгэр, Б.Өлзийбуян, Г.Шийлэгдамба, Б.Дашзэвэг нарын гаалийн байцаагчид, Н.Ариунгэрэл, Б.Насандэлгэр, Л.Алтанхуяг, М.Амартүвшин, Д.Алтангадас, Н.Билэгбаатар, С.Галбадрах, Ли Жонг Ёл нарт холбогдох эрүүгийн хэрэг, “Монголиан коппер корпорейшн”, “Улаанбаатар төмөр зам”, “Ноён уулаа аврах” НҮТББ-ын нэхэмжлэлтэй иргэний хэргүүд болон намуудын бүртгэл хүсэлт зэргийг шийдвэрлэсэн онцлох шүүх хуралдаанууд болж өнгөрлөө.



Мөн хугацаанд тус хэлтэст иргэн, албан тушаалтан, байгууллагаас ирүүлсэн нийт **143** албан бичиг, өргөдөл, гомдол, хүсэлтийг зохих журмын дагуу хүлээн авч, судлан холбогдох албан тушаалтанд танилцуулан, хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, хариуг хүргүүлсэн байна.

Шүүхийн захиргааны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т заасан чиг үүргийн дагуу /шүүгчийн туслахууд/ шүүгчид хуваарилагдсан хэрэг, маргааны талаарх бичиг баримтын бүрдлийг судалж, хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан шүүгчээс даалгасан ажиллагааг гүйцэтгэх, техник зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, хэрэг маргаан шийдвэрлэхэд шаардлагатай хууль тогтоомжийн талаар болон бусад мэдээлэл бэлтгэх, хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтыг хангах, тогтоол, захирамжийн төсөл боловсруулах зэрэг ажлуудыг гүйцэтгэжээ.

Шүүхийн захиргааны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т заасан чиг үүргийн дагуу /шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нар/ шүүх хуралдааны техник, зохион байгуулалтын бэлтгэлийг хангаж эрүүгийн **627**, иргэн **2126**, захиргааны хэргийн **671** нийт **3105** шүүх хуралдааны тэмдэглэл хөтөлж, шүүх хуралдааныг дуу болон дүрс бичлэгээр баталгаажуулж, шүүх хуралдааны тэмдэглэлийг хэргийн оролцогчдод хуульд заасан хугацаанд танилцуулан, шүүгчээр баталгаажуулж, хэргийн материалд хавсаргажээ.

Улсын Дээд шүүхийн шүүн таслах, шүүхийн нийтлэг үйлчилгээний ажлыг хэвийн, тасралтгүй явуулах нөхцөлийг ханган, цахим санд хяналтын шатны шүүх хуралдааны зар, тойм **3597** байршуулж, хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдсэн эрүүгийн **570**, иргэний **1867**, захиргааны **497** тогтоолыг хууль, журамд заасны дагуу шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулсан байна.

### 3.6. Шүүхийн хэвлэл мэдээллийн чиглэлээр:

Тус хэлтэс нь Улсын Дээд шүүхийн шүүн таслах болон бусад үйл ажиллагааны талаар давхардсан тоогоор өдөр тутмын сонинд **65**, телевизэд **116**, радиод **40**, вэб сайтуудад **258** мэдээ, мэдээлэл бэлтгэн нийтлүүлж нэвтрүүлжээ.

Мөн телевизүүдийн урсдаг мэдээгээр давхардсан тоогоор **84** мэдээг олон нийтэд хүргэсэн байна.

#### 1.6.1. Телевизийн нэвтрүүлгийн хувьд:

Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч **Д.Золзаяа** 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр МҮОНТ-ийн “Эрх зүйн хөтөч” нэвтрүүлэгт оролцож “**Өв залгамжлалын маргаан**” сэдвээр зохиомжит нэвтрүүлэг, ярилцлага;



Улсын Дээд шүүхийн шүүгч **Г.Банзрагч** 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдөр “25-р суваг” телевизийн мэдээллийн хөтөлбөрөөр “**Захиргааны ерөнхий хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**” хуулийн сэдвээр ярилцлага;

шүүгч **Б.Батцэрэн** 2018 оны 12 дугаар сарын 08-ны өдөр, шүүгч **Ч.Хосбаяр** 2018 оны 12 дугаар сарын 22-ны өдөр VTV телевизийн “SYNDICATE TALK” нэвтрүүлэгт оролцож “**Эрүүгийн эрх зүйн шинэтгэл**” сэдвээр ярилцлага хийж олон нийтийн хүртээл болгожээ.

### **1.6.2. Сонин, сайтын нийтлэлийн хувьд:**

Шүүхийн талаар бодит ойлголт олон нийтэд хүргэх үүднээс шүүх, шүүгчийн үйл ажиллагаа, шүүхийн шийдвэртэй холбоотой давхардсан тоогоор ярилцлага, нийтлэл, мэндчилгээ, хагас жилийн шүүн таслах ажлын дэлгэрэнгүй мэдээлэл нийт **67**-ыг сонин сайтад нийтлүүлжээ.

Шүүгч Ч.Хосбаяр “Шүүх эрх мэдэл” мэдээлэл арга зүйн улирал тутмын эмхтгэл, 2018 он, дугаар №01-д “Олон улсын эрх зүйн эх сурвалжид хандах нь” сэдэвт өгүүлэл, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн “Эрх зүй” онол, практик, арга зүйн мэргэжлийн улирал тутмын сэтгүүл, 2018 он, дугаар №04-д ““Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэг ба авлигын эсрэг олон улсын конвенцууд дахь түүний агуулга” сэдэвт өгүүлэл;

Шүүгч **Д.Цолмон** Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн Монгол Улсын хуулийн 1, 2 дугаар зүйлд заасан зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх асуудлаар Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцэд мэдүүлсэн хүсэлтэд Дээд шүүхийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаан хийх эрх зүйн зохицуулалтын талаар “Өдрийн сонин”-д ярилцлага;

2018 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Өдрийн сонинд “Засгийн газарт Захиргааны ерөнхий хууль үйлчлэх үү” сэдвээр ярилцлага тус тус өгсөн байна.

### **3.7. Ерөнхий шүүгчийн ажлын алба:**

Тус алба нь тайлангийн хугацаанд нийт **293** албан бичиг, **70** өргөдөл, гомдол хүлээн авч, хуулийн хугацаанд нь хариу өгчээ.

Ерөнхий шүүгчид гаргасан гомдлыг үндэслэн Ерөнхий шүүгчийн ажлын алба эрүүгийн **91** /үүнээс М.Дамирансүрэн **26**, С.Батдэлгэр **65** хэрэг/, иргэний **3**, захиргааны **96**, /хариу өгсөн **85**, үлдэгдэл **13**/ нийт **186** хэрэг хүлээн авч, Ерөнхий



шүүгчид танилцуулж, хариу өгсөн. эрүүгийн **3** хэрэгт дүгнэлт бичигдэж, биелэгдсэн байна.

Ажлын албаны дарга, бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан шинжээчийг байлцуулан хэргийн оролцогчид болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгч **128** хүнийг сар бүрийн **4** дүгээр **7** хоногийн **пүрэв** гарагт болон хөдөө орон нутгаас ирсэн иргэдийг тухайн өдөрт нь хүлээн авч уулзан санал хүсэлтийг нь сонсож, тэдний санал, хүсэлтийг Ерөнхий шүүгчид тухай бүрт нь танилцуулж, зохих хариуг өгчээ.

Өргөдөл, гомдолд өгсөн хариунаас **98** иргэн үл зөвшөөрч дахин гомдол ирүүлснийг /өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэх журмын дагуу/ тамгын газрын дарга буцаасан байна. Мөн хяналтын шатны эрүүгийн хэргийн талаар хэргийн холбогдогч, хохирогч, өмгөөлөгч нараас ирсэн гомдлыг үндэслэн нийслэлийн дүүрэг, аймгаас **29** хэргийг практик судлалын хэлтэстэй хамтарч судлан танилцуулга бичиж, Ерөнхий шүүгч, Танхимын тэргүүн нарт танилцуулснаас гадна гомдол гаргасан **13** иргэнд зохих хариу өгчээ.

Улсын Дээд шүүхийн дотоод аудитор нь байгууллагын оршин байгаа алдаа зөрчлийг тайлагнахаас илүүтэйгээр байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, гарч болох алдаанаас сэргийлэх, дотоод хяналтын сул талыг сайжруулахад чиглэн ажиллаж байна.

Дотоод аудитор нь Төсвийн тухай хууль, Дотоод аудитын дүрэм, Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай Засгийн газрын тогтоол, Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын хүрээнд дотоод бүтэц чиг үүргийг боловсронгуй болгон төлөвшүүлэх, улмаар байгууллагын үйл ажиллагааны санхүү төсөв, шилэн данс, хүний нөөцийн менежмент, шүүхийн байрны аюулгүй байдал-хамгаалалт, шүүхийн захирааны ажилтны сургалт, тэдний ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх зэрэгт гол анхаарлаа төвлөрүүлэн ажиллаж байна.

Дотоод аудитын ажлыг хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүү, төсвийн удирдлага, хэргийн хөдөлгөөний менежмент гэсэн үндсэн чиглэлүүдээр төлөвлөн **5** нэр төрлийн аудитыг хийж хэрэгжүүллээ.

2018 онд дотоод хяналтыг үр дүнтэй явуулж, эрсдэлээс сэргийлэн шүүхийн захиргааны удирдлагын тогтолцоог боловсронгуй болгосноор тайлант хугацаанд санхүүгийн болон шүүхийн захиргааны ажилтнуудын үйл ажиллагаатай холбоотой ноцтой зөрчил гараагүй зэрэг нь дотоод аудитын үр дүн юм.



Улсын Дээд шүүх цагаатгалын үнэмлэх олгох талаар хэлмэгдэгчдийн төрөл садан болон Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссуудаар дамжуулан **111** өргөдөл, хүсэлтийг хүлээн авч нийтдээ шинээр **26** үнэмлэх олгож, **20** үнэмлэх нөхөн олгожээ.

### 3.8. Шүүхийн Гадаад арга хэмжээний чиглэлээр:

Шүүхийн гадаад харилцаа жилээс жилд өргөжин тэлж шүүгч, ажилтнууд тив дэлхийн болон олон улсын бүсийн чуулга уулзалт, эрдэм шинжилгээний бага хуралд оролцож, шүүн таслах ажиллагааны талаарх туршлага судлах ажил өргөжсөөр байна. Тухайлбал:

- шүүгч **Х.Батсүрэн** Бүгд Найрамдах Турк Улсын Хяналтын шатны шүүх байгуулагдсаны 150 жилийн ойн арга хэмжээний хүрээнд тус улсын Анкара хотноо 2018 оны 3 дугаар сарын 6-10-ны өдрүүдэд “**Бүгд Найрамдах Турк Улсын Хяналтын шатны шүүх байгуулагдсаны 150 жил**” сэдэвт олон улсын хуралд;

- Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь** Бразил улсын Дээд шүүх, Дэлхийн Байгаль Орчны Эрх Зүйн Комисс (WCEL)-оос хамтран Бразил улсын Бразилиа хотноо 2018 оны 3 дугаар сарын 19-23-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “**Дэлхийн Усны эрх зүйн 8 дугаар**” сургалт, форумд;

- Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн **Б.Цогт**, Улсын Дээд шүүхийн шүүгч **Д.Цолмон**, **Б.Мөнхтуяа**, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч **Д.Батбаатар**, Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх шүүгч **М.Пүрэвсүрэн**, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч **И.Ичинхорлоо**, Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч **Б.Мөнхбаяр** нар Испанийн Вант Улсын Дээд шүүх, Шүүхийн сургуулиас 2018 оны 03 дугаар сарын 19-23-ны өдрүүдэд Испанийн Вант Улсын Мадрид, Барселон хотноо зохион байгуулсан Монгол Улсын шүүхийн шүүгч нарт зориулсан ээлжит сургалтад;

- шүүгч **Б.Батцэрэн** Австри Улсын Вен хотноо, НҮБ-ийн Мансууруулах бодис гэмт хэрэгтэй тэмцэх албанаас 2018 оны 04 дүгээр сарын 09-10-ны өдрүүдэд зохион байгуулагдах “**Шүүх эрх мэдлийн халдашгүй байдлын асуудлаарх дэлхийн сүлжээний нээлт**” сэдэвт олон улсын чуулга уулзалтад;

- шүүгч **Д.Мөнхтуяа** Бүгд Найрамдах Турк Төрийн зөвлөл байгуулагдсаны 150 жилийн ойн арга хэмжээний хүрээнд тус улсын Анкара хотноо 2018 оны 5 дугаар



сарын 09-13-ны өдрүүдэд **“Бүгд Найрамдах Турк Төрийн зөвлөл байгуулагдсаны 150 жил ба Захиргааны шүүх”** сэдэвт олон улсын хуралд;

- Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь**, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Д.Тулга** нар БНХАУ-ын Ардын Дээд шүүхээс тус улсын Бээжин хотноо 2018 оны 5 дугаар сарын 23-27-ны өдрүүдэд зохион байгуулагдсан **“Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын Дээд шүүхийн тэргүүн нарын XIII хурал”**-д оролцож, Шүүхийн хамтын ажиллагаа сэдэвт илтгэл, Монгол Улсын Дээд шүүх болоод БНХАУ-ын Ардын Дээд шүүх хоорондын хамтын ажиллагааны санамж бичгийг үзэглэлээ.

- Гадаад харилцаа, хамтын ажиллагааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Д.Тулга** БНХАУ-ын Бээжин хотноо 2018 оны 6 дугаар сарын 12-15-ны өдрүүдэд зохион байгуулагдсан **“Монгол Улс, БНХАУ-ын Гадаад хэргийн яамд хоорондын Консулын зөвлөлдөх уулзалт”**;

- шүүгч **Л.Атарцэцэг** Бүгд Найрамдах Турк Улсын Дээд шүүх байгуулагдсаны 150 жилийн ойн арга хэмжээний хүрээнд Турк улсын Дээд шүүх, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран тус улсын Истанбул хотноо 2018 оны 10 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд **“Шүүхийн ил тод байдал”** сэдэвт олон улсын хуралд;

- шүүгч **Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, Х.Эрдэнэсүвд**, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч **Д.Дэлгэрцэцэг**, Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч **Н.Одонтуул**, Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч **С.Амардэлгэр**, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч **Б.Халиун** нар Испанийн Вант Улсын Дээд шүүх, Шүүхийн сургуулиас 2018 оны 10 дугаар сарын 19-23-ны өдрүүдэд Испанийн Вант Улсын Мадрид, Барселон хотноо зохион байгуулсан **“Монгол Улсын шүүхийн шүүгч нарт зориулсан ээлжит”** сургалтад;

- Иргэний хэргийн танхимын тэргүүн **Х.Сонинбаяр**, шүүгч **Ц.Амарсайхан, П.Золзаяа** нар Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн урилгаар 2018 оны 11 дүгээр сарын 11-18-ны өдрүүдэд ХБНГУ-ийн Бавар мужийн Деггендорф, Мюнхен хотуудад **“Иргэний хэргийн талаар Монгол Улсын шүүхийн шүүгч нарт зориулсан”** сургалт, айлчлал;

- Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн **Б.Цогт**, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч **Э.Халиунбаяр**, Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч **Ё.Бямбацэрэн**, Хэнтий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч **Б.Сүхгомбо**, Хан-Уул дүүргийн



Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч И.Ганбат, Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Х.Идэр, Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Д.Оюумаа, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Д.Тулга** нар БНЭУ-ын Лакноу хотноо 2018 оны 11 дүгээр сарын 12-22-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “**Дэлхийн Ерөнхий шүүгч нарын 19 дүгээр чуулга уулзалт**”-д тус тус оролцжээ.

**Гадаад хамтын ажиллагааны хүрээнд:**

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь**, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Д.Тулга** нар Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрх, ундны усны аюулгүй байдал, ариун цэврийн байгууламжийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч Лео Хеллерыг 2018 сарын 4 дүгээр сарын 23-ны өдөр хүлээн авч уулзлаа.

**Шүүхийн даалгаврын хүрээнд:**

Шүүхийн даалгавар буюу эрх зүйн туслалцааг хилийн чандад илгээх болон хилийн чанадаас ирсэн хүсэлтийг Иргэний хэргийн хувьд хариуцах Дээд шатны байгууллага нь Улсын Дээд шүүх бөгөөд гадаад улсад нийт **19** шүүхийн даалгавар илгээснээс БНСУ-д **12**, БНХАУ-д **2**, Унгар, Итали, ОХУ, Япон, Британийн Виржиний Арлууд улсуудад тус тус **1** шүүхийн даалгавар илгээгээд байгаагаас БНСУ-д илгээсэн **6**, Унгар болон Япон улсуудад илгээсэн шүүхийн даалгаврын хариу ирсэн байна.

Харин БНСУ-аас **7** шүүхийн даалгавар ирснийг харьяалах шүүхэд хүргүүлэн гүйцэтгүүлэх арга хэмжээг авсан байна.

**Гадаад харилцаа хамтын ажиллагааны албаны бусад чиг үүргийн хүрээнд:**

Гадаад харилцааны асуудлаар хийх уулзалт, зөвлөгөөний бэлтгэлийг урьдчилан хангаж, удирдлагыг тухайн асуудлаарх шаардлагатай мэдээллээр ханган Ерөнхий шүүгч болон шүүгчдийг гадаадын зочид, төлөөлөгчидтэй уулзах үед орчуулагчаар ажилласан байна.

Гадаадын байгууллага, иргэдээс ирсэн албан бичиг, захидал, зохиол, бусад материалыг монгол хэлнээ хөрвүүлэн, Ерөнхий шүүгчид танилцуулсан, Ерөнхий шүүгчээс гадаадын байгууллага, иргэдэд явуулж буй албан бичиг, захидал, урилгыг англи хэл дээр хөрвүүлжээ.





Бусад улс орны шүүхийн үйл ажиллагааны туршлага судалж, манай улс оронд нэвтрүүлж болох зүйлийг хэрэгжүүлэх талаар анхаарал хандуулан ажиллаж байна.

### 3.9. Шүүхийн сургалт, семинарын чиглэлээр:

#### Эрүүгийн хэргийн танхим

Улсын Дээд шүүхээс 2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдрөөс 02 дугаар сарын 01-ний өдрүүдэд анхан болон давж заалдах шатны нийт шүүхүүдийн Ерөнхий шүүгч нарын дунд зохион байгуулсан “Шүүн таслах ажиллагаа, шүүхийн шийдвэрийн талаарх практик” сэдэвт сургалт-уулзалт, ярилцлагад Танхимын тэргүүн **Б.Цогт** “Эрүүгийн хэргийн шүүн таслах ажиллагааны 2017 оны алдаа зөрчлийн тойм”, шүүгч **С.Батдэлгэр** “Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн зарим зүйл, заалтыг хэрэглэх талаар”, шүүгч **Б.Батцэрэн** “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн талаар”, шүүгч **Д.Ганзориг** “Хууль буцаан хэрэглэх тухай”, шүүгч **Ч.Хосбаяр** “Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн талаар”, шүүгч **Д.Эрдэнэбалсүрэн** “Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, хорих ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай” сэдвээр тус тус хичээл заажээ.

Эрүүгийн хэргийн танхимын шүүгч нар 2018 оны 5 дугаар сарын 10, 14-ний өдрүүдэд Нийслэл болон Төв аймаг дахь Эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхүүдийн Ерөнхий шүүгч, шүүгч нартай “Шүүн таслах ажиллагаа, шүүхийн шийдвэрийн талаарх практик” сэдэвт уулзалт-ярилцлага;

Танхимын тэргүүн **Б.Цогт** 2018 оны 6 дугаар сарын 04-06-ны өдрүүдэд Дорнод, Хэнтий аймаг дахь Эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нарт;

шүүгч **Ч.Хосбаяр** 2018 оны 6 дугаар сарын 04-05-ны өдрүүдэд Баян-Өлгий аймаг дахь Эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нарт;

2018 оны 6 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд Ховд аймаг дахь Эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нарт;

2018 оны 6 дугаар сарын 12-15-ны өдрүүдэд Завхан, Говь-Алтай аймаг дахь Эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нарт;

шүүгч **Д.Эрдэнэбалсүрэн** 2018 оны 6 дугаар сарын 04-09-ний өдрүүдэд Булган, Орхон, Дархан, Хөвсгөл, Сэлэнгэ аймаг дахь Эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нарт;





шүүгч **Б.Батцэрэн** 2018 оны 6 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд Өмнөговь аймаг дахь Эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нарт;

2018 оны 6 дугаар сарын 05-07-ны өдрүүдэд Дундговь аймаг дахь Эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нарт;

2018 оны 6 дугаар сарын 08-10-ны өдрүүдэд Дорноговь аймаг дахь Эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нарт;

шүүгч **Д.Ганзориг** 2018 оны 6 дугаар сарын 05-07-ны өдрүүдэд Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймаг дахь Эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нартай уулзалт ярилцлага зохион байгуулж, шүүн таслах ажиллагааны практикийг судалж, шүүн таслах ажиллагааг нэг мөр хэрэгжүүлэх талаар санал солилцож оролцлоо.

2018 оны 3 дугаар сарын 29-ний өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан “Шүүгчийн ёс зүй” сэдэвт сургалтад шүүгч **Б.Батцэрэн, Д.Ганзориг, Ч.Хосбаяр, Д.Эрдэнэбалсүрэн** нар хамрагдсан байна.

Мөн шүүгч **Ч.Хосбаяр** Авлигатай тэмцэх газраас 2018 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулсан “Эрүүгийн хэрэг дэх эрх зүйн харилцан туслалцаа-хамтын ажиллагаа” сэдэвт хэлэлцүүлэгт “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ, олон улсын гэрээний үндсэн дээр олж авсан баримтыг нотлох баримтын хэмжээнд үнэлэх шүүхийн практик” сэдэвт илтгэл;

Шүүгч **Б.Батцэрэн** Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2018 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгуулсан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулиас: зүйлчлэлийг өөрчилж ял хүндрүүлэх нөхцөлд шүүхээс хэргийг прокурорт буцаах нь” хэлэлцүүлэгт “Эрүүгийн хэргийг прокурорт буцаах эрх хэмжээ” сэдвээр илтгэл хэлэлцүүлж нийтлүүлжээ.

Түүнчлэн шүүгч **Б.Батцэрэн** 2018 оны 10 дугаар сарын 04 болон 18-ны өдрүүдэд Үндсэн хуулийн цэцийн тамгын газрын ажилтнуудад;

Шүүгч **Б.Батцэрэн, Д.Ганзориг, Ч.Хосбаяр, Д.Эрдэнэбалсүрэн** нар 2018 оны 11 дүгээр сарын 14-16-ны өдрүүдэд Улсын Дээд шүүхийн Тамгын газар, Монголын Хуульчдын холбоотой хамтран зохион байгуулсан хуульчийн кредит цагийн сургалтыг удирдан явуулж “Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль” сэдвээр хичээл заасан байна.

### Иргэний хэргийн танхим



2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдрөөс 02 дугаар сарын 01-ний өдрүүдэд Улсын Дээд шүүхээс зохион байгуулсан **“Шүүн таслах ажиллагаа, шүүхийн шийдвэрийн талаарх практик”** сэдэвт сургалт-уулзалт ярилцлагад Танхимын тэргүүн **Х.Сонинбаяр** “2017 онд улсын хэмжээнд болон Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн иргэний хэрэг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны алдаа зөрчлийн тойм, анхаарах асуудал” сэдвээр;

шүүгч **Г.Алтанчимэг** “Хяналтын шатны шүүх хуралдаанаас магадлалыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээсэн, өөрчлөлт оруулсан үндэслэл, нотлох баримтыг хуульд заасан журмын дагуу үнэлэх” сэдвээр;

шүүгч **Ц.Амарсайхан** “Хяналтын шатны шүүх хуралдаанаас шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан болон давж заалдах шатны шүүхэд буцаасан үндэслэл, хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, хуулийг зөв хэрэглэхэд анхаарах талаар” сэдвээр;

шүүгч **П.Золзаяа, Г.Цагаанцоож** нар “Хяналтын шатны шүүх хуралдаанаар шийдвэрлэгдсэн Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гомдолтой хэргийн судалгаа, алдаа зөрчлийн тойм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /2017 он/ зарим заалтыг зөв хэрэглэх талаар” сэдвээр;

шүүгч **Д.Цолмон** “Хяналтын шатны шүүх хуралдаанаас шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон үндэслэл, ИХШХШТХ-ийн 117, 106 дүгээр зүйлийн практик хэрэглээ” сэдвээр;

шүүгч **Х.Эрдэнэсүвд** “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааны талаарх судалгаа, дүгнэлт” сэдвээр тус тус сургалт явуулжээ.

2018 оны 5 дугаар сарын 11-ний өдөр Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын шүүгч нар “Иргэний хэргийн шүүн таслах ажиллагааны практик” сэдвээр анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчтэй хийх уулзалт-ярилцлага”-ын хүрээнд Төв аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах, Багахангай-Налайх, Багануур дүүргийн анхан шатны шүүхийн шүүгч нарт;

2018 оны 5 дугаар сарын 09-ний өдөр Нийслэлийн Иргэний хэргийн анхан шатны шүүхүүдийн шүүгч нарт;

2018 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч нартай уулзалт-ярилцлагыг тус тус зохион байгууллаа.

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2018 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 213 дугаар захирамжаар баталсан **“Шүүн таслах ажиллагааны практик**



**судлах, анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч нартай хийх уулзалт, ярилцлага**”-ын удирдамжийн дагуу:

Танхимын тэргүүн **Х.Сонинбаяр** 2018 оны 6 дугаар сарын 03-07-ны өдрүүдэд Өмнөговь, Дундговь аймаг дахь Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нарт;

шүүгч **Ц.Амарсайхан** 2018 оны 6 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд Баян-Өлгий, Ховд аймаг дахь Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нарт;

2018 оны 6 дугаар сарын 12-15-ны өдрүүдэд Завхан, Говь-Алтай аймаг дахь Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нарт;

шүүгч **Г.Алтанчимэг** 2018 оны 6 дугаар сарын 05-07-ны өдрүүдэд Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймаг дахь Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нарт;

шүүгч **П.Золзаяа** 2018 оны 6 дугаар сарын 04-09-ний өдрүүдэд Булган, Орхон Дархан, Хөвсгөл, Сэлэнгэ аймаг дахь Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нарт;

шүүгч **Б.Ундрах** 2018 оны 6 дугаар сарын 05-08-ны өдрүүдэд Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймаг дахь Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нарт;

шүүгч **Х.Эрдэнэсүвд** 2018 оны 6 дугаар сарын 08-10-ны өдрүүдэд Дорноговь, Говьсүмбэр аймаг дахь Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нартай уулзалт ярилцлага тус тус зохион байгуулжээ.

Иргэний хэргийн танхимын шүүгч нар 2018 оны 3 дугаар сарын 30-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан “Шүүгчийн ёс зүй” сэдэвт;

2018 оны 4 дүгээр сарын 23-27-ны өдрүүдэд ХБНГУ-ын Бавари мужийн Ньурнберг хот дахь Дээд шүүхийн шүүгч асан **Ё.Кают** багш удирдан явуулсан “Бусдын эзэмшил, ашиглалтад хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон гэрээний эрх зүй ба Иргэний хуулийн хэрэглээ” сэдэвт сургалтад тус тус хамрагдаж,

Мөн 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдөр Гэр бүлийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төсөл боловсруулахтай холбоотойгоор Шүүхийн Ерөнхий зөвлөлийн байранд хурал, хэлэлцүүлэгт оролцжээ.

Шүүгч **Ц.Амарсайхан** 2018 оны 10 дугаар сарын 03, 11-ний өдрүүдэд шүүгч нарт “Бусдын эзэмшил ашиглалтад хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон гэрээний эрх зүйн харилцаа” сэдвээр;



Шүүгч **Г.Цагаанцоож, Д.Цолмон, Б.Ундрах** нар 2018 оны 11 дүгээр сарын 14-16-ны өдрүүдэд Улсын Дээд шүүхийн Тамгын газар, Монголын Хуульчдын холбоотой хамтран зохион байгуулсан хуульчийн кредит цагийн сургалтыг удирдан явуулж “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, Оюуны өмчийн эрх зүй, Хөдөлмөрийн эрх зүй” сэдвээр хичээл заасан байна.

### Захиргааны хэргийн танхим

Улсын Дээд шүүхээс 2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдрөөс 02 дугаар сарын 01-ний өдрүүдэд анхан болон давж заалдах шатны нийт шүүхүүдийн Ерөнхий шүүгч нарын дунд зохион байгуулсан “Шүүн таслах ажиллагаа, шүүхийн шийдвэрийн талаарх практик” сэдэвт сургалт-уулзалт, ярилцлагад Танхимын тэргүүн **М.Батсуурь** “Захиргааны ерөнхий хуулийг шүүхэд хэрэглэж буй практик хэлэлцүүлэг” сэдвээр;

Танхимын тэргүүн **М.Батсуурь**, шүүгч **Л.Атарцэцэг** нар “Захиргааны хэргийн шүүн таслах ажиллагааны 2017 оны алдаа зөрчлийн тойм” сэдвээр;

шүүгч **Б.Мөнхтуяа, П.Соёл-Эрдэнэ** нар “Төрийн албаны маргаан шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудал болон эрх зүйн шинэчлэл” сэдвээр;

2018 оны 3 дугаар сарын 09-ний өдөр шүүгч **П.Соёл-Эрдэнэ** Монголын Хуульчдын холбооноос зохион байгуулсан сургалтад “Захиргааны хэргийн шүүхэд гаргах нэхэмжлэлийн төрлүүд, захиргааны хэргийн шүүхийн хяналтын цар хүрээ” сэдвээр;

Танхимын тэргүүн **М.Батсуурь** 2018 оны 8 дугаар сарын 28-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүхийн мэргэшсэн сэтгүүлч нарт зориулсан сургалтад “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог” сэдвээр;

шүүгч **Г.Банзрагч** 2018 оны 7 дугаар сарын 05-нд Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан “Шүүгч бэлтгэх сургалт”-нд “Хууль хэрэглэх онол, арга зүй” сэдвээр;

2018 оны 9 дүгээр сарын 21-нд Хуульчдын холбооноос зохион байгуулсан хуульчийн шалгалтад бэлдэх 4 цагийн сургалтанд;

2018 оны 10 дугаар сарын 26-нд Хүний эрхийн үндэсний комиссоос зохион байгуулдаг цуврал лекцэд “Эрх зүйт төр ба Захиргааны хэргийн шүүх” сэдвээр;

Шүүгч **П.Соёл-Эрдэнэ** 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдөр Хуульчдын холбооны гишүүдэд “Захиргааны хэргийн шүүхийн хяналтын цар хүрээ” сэдвээр;

2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр “Төрийн албаны маргаан” сэдвээр;



2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Улсын Дээд шүүхийн хуульчийн гэрчилгээ бүхий албан хаагч нарт “Төрийн албаны маргаан” сэдвээр тус тус хичээл заажээ.

Танхимын тэргүүн **М.Батсуурь** 2018 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрх, ундны усны аюулгүй байдал, ариун цэврийн байгууламжийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч Лео Хеллертэй уулзалт ярилцлага;

шүүгч **Г.Банзрагч** 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдөр MN-25 дугаар суваг телевизэд “Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”-ийн талаар уулзалт ярилцлага;

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2018 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 213 дугаар захирамжаар баталсан “**Шүүн таслах ажиллагааны практик судлах, анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч нартай хийх уулзалт, ярилцлага**”-ын удирдамжийн дагуу:

шүүгч **Ч.Тунгалаг** 2018 оны 6 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд Өмнөговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нарт;

2018 оны 6 дугаар сарын 05-07-ны өдрүүдэд Дундговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нарт;

шүүгч **Л.Атарцэцэг** 2018 оны 6 дугаар сарын 04-09-ний өдрүүдэд Булган, Орхон, Дархан, Хөвсгөл, Сэлэнгэ аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нарт;

шүүгч **Г.Банзрагч** 2018 оны 6 дугаар сарын 04-06-ны өдрүүдэд Дорнод, Сүхбаатар аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нарт;

2018 оны 6 дугаар сарын 06-08-ны өдрүүдэд Хэнтий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нарт;

шүүгч **Д.Мөнхтуяа** 2018 оны 6 дугаар сарын 08-10-ны өдрүүдэд Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчид, Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчид, Говьсүмбэр аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нарт;

шүүгч **Б.Мөнхтуяа** 2018 оны 6 дугаар сарын 05-07-ны өдрүүдэд Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нарт;



шүүгч **П.Соёл-Эрдэнэ** 2018 оны 6 дугаар сарын 04-05-ны өдрүүдэд Баян-Өлгий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нарт;

2018 оны 6 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд Ховд аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нарт;

2018 оны 6 дугаар сарын 12-15-ны өдрүүдэд Завхан, Говь-Алтай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нарт уулзалт ярилцлага тус тус зохион байгуулжээ.

2018 оны 3 дугаар сарын 17-ны өдөр Монголын Хуульчдын холбооны Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хорооноос зохион байгуулсан сургагч багш нарт зориулсан сургалт хэлэлцүүлэгт шүүгч **Г.Банзрагч** “Хуульчийн үргэлжилсэн сургалтын зорилго, үр нөлөө” сэдэвт хэлэлцүүлгийн чиглүүлэгчээр;

2018 оны 6 дугаар сарын 14-ний өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлийн 25 жилийн ойд зориулсан “Шүүхийн захиргааны хөгжлийн чиг хандлага: чиг үүрэг ба загвар” сэдэвт онол практикийн Олон улсын бага хуралд шүүгч **Ч.Тунгалаг**, **Д.Мөнхтуяа** нар оролцож, Танхимын тэргүүн **М.Батсуурь** “Шүүх эрх мэдэл ба иргэдийн итгэл” сэдэвт салбар хуралдааны панелистаар, шүүгч **Г.Банзрагч** “Шүүхийн захиргааны чиг үүрэг ба загвар” сэдэвт салбар хуралдааны панелистаар;

Танхимын тэргүүн **М.Батсуурь** 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Монгол Хуульчдын холбооноос зохион байгуулсан “Хуульчдын форум-2018”-ын “Олон улсын хуульчдын Байгаль орчныг хамгаалахад гүйцэтгэх үүрэг, чиг хандлага, шаардлагатай мэдлэгийн түвшин” сэдэвт салбар хуралдаанд панелистаар,

2018 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн ажлын хэсгийн хуралдаанд,

2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр “Шүүхийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг”-ийн төсөл боловсруулах ажлын хэсгийн хуралдаанд;

шүүгч **Д.Мөнхтуяа** “Хараат бус шүүх ба хууль дээдлэх ёс” сэдэвт салбар хуралдааны панелистаар;

шүүгч **Г.Банзрагч** 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдөр “Хуульчдийн форум-2018” хэлэлцүүлэгт “Чанартай хууль зүйн боловсрол: магадлан итгэмжлэл ба үргэлжилсэн сургалт” сэдэвт салбар хуралдааны панелистаар,

“Чанартай хууль зүйн боловсрол: магадлан итгэмжлэл ба үргэлжилсэн сургалт” сэдэвт салбар хуралдааны панелистаар,

2018 оны 12 дугаар сарын 07-ны өдөр “Хүний эрхийн соёлийг бэхжүүлэх нь” симпозиумд “Хүний эрхийн боловсролын сайн туршлагаас” сэдэвт салбар



хуралдаанд хуульч, хууль сахиулагчдын хүрээнд чиглүүлэгч буюу панелистаар тус тус оролцжээ.

2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Япон Улсын Нагояагийн их сургуулиас санаачлан Хууль зүйн үндэсний хүрээлэн, МУИС-ын Хууль зүйн сургууль, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хамтран зохион байгуулсан “ЗХШХША-ны хөгжил: Захиргааны хяналтаас шүүхийн хамгаалал руу шилжсэн үү” сэдэвт лекцэнд шүүгч **Д.Мөнхтуяа** шүүмжлэгчээр оролцож, шүүгч **Л.Атарцэцэг, Х.Батсүрэн, П.Соёл-Эрдэнэ, Б.Мөнхтуяа** нар хамрагджээ.

Мөн 2018 оны 5 дугаар сарын 18-ны өдөр шүүгч **Л.Атарцэцэг, Г.Банзрагч, Ч.Тунгалаг, П.Соёл-Эрдэнэ** нар Хууль зүйн үндэсний хүрээлэнд зохион байгуулагдсан доктор Юрген Харбихын лекцэнд хамрагдсан байна.

2018 оны 03 дугаар сарын 29-ний өдөр шүүгч **Л.Атарцэцэг, Г.Банзрагч, Б.Мөнхтуяа, Ч.Тунгалаг, П.Соёл-Эрдэнэ** нар Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан “Шүүгчийн ёс зүй” сэдэвт сургалтад;

2018 оны 5 дугаар сарын 16-ны өдөр шүүгч **Д.Мөнхтуяа** Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхээс зохион байгуулсан “Эрх зүй ба эдийн засаг” эрдэм шинжилгээний бага хуралд;

2018 оны 10 дугаар сарын 08-ны өдөр Нагояагийн Их сургууль, Ханнс зайделын сан, Монгол Улсын Их сургууль, Чимид сангаас хамтран зохион байгуулсан “Үндсэн хуулийн болон захиргааны эрх зүйн үндсэн асуудал” сэдэвт Олон Улсын эрдэм шинжилгээний хуралд “Захиргааны эрх зүй дэх субъектив эрхийн зарим асуудал: албан тушаалтны эрх хуулиар зөвшөөрсөн бол хориглогдох зарчимд үндэслэх нь” сэдвээр илтгэл тавьж тус тус оролцжээ.

Шүүгч **Г.Банзрагч** Монголын Хуульчдын холбооны Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хорооны хуралд 6 удаа оролцож, Танхимын тэргүүн **М.Батсуурь**, шүүгч **Д.Мөнхтуяа** нар Шүүхийн Ерөнхий зөвлөлийн мэргэшлийн хорооноос зохион байгуулсан шүүгчийн сонгон шалгаруулалтын шалгалт авч, үнэлгээ өгөх ажиллагаанд оролцсон байна.

### **Тамгын газар**

Тамгын газар нь 2018 оны 01 дүгээр сарын 31-нээс 2 дугаар сарын 01-ний өдрүүдэд анхан болон давж заалдах шатны нийт шүүхүүдийн Ерөнхий шүүгч нарт “Шүүн таслах ажиллагаа, шүүхийн шийдвэрийн талаарх практик” сэдэвт сургалт-уулзалт, ярилцлага;





2018 оны 6 дугаар сарын 04-15-ны өдрүүдэд Зүүн, Баруун, Хангайн, Говийн, Төвийн бүсийн шүүхүүдийн Ерөнхий шүүгч, шүүгч нартай хийх уулзалт-ярилцлагыг амжилттай зохион байгууллаа.

2018 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр Монгол банктай хамтран “Төв банк ба валютын ханш, түүнд нөлөөлөх хүчин зүйл, олон улсын туршлага” сэдвээр сургалт; хот суурин газрын авто замын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулах, иргэдийг эрүүл амьдралын хэвшилд сургах, эмийн хэрэглээг багасгаж эрүүл амьдралыг чухалчлах “Унадаг дугуйн соёл”-ыг нэвтрүүлэх зорилгоор “Тайван байк” ХХК-тай хамтран “Дугуйтай монгол” төслийн талаар мэдээлэл;

2018 оны 5 дугаар сарын 02-ны өдөр Тагнуулын Ерөнхий газартай хамтран “Төрийн болон албаны нууцын тухай” хууль тогтоомжийн талаарх сургалт;

2018 оны 11 дүгээр сарын 14-16-ны өдрүүдэд Хуульчийн үргэлжилсэн багц цагийн сургалт;

2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн хэрэгжилтийг хангах, албан хаагч нараар хууль судлуулах зорилгоор сургалт тус тус зохион байгуулж төрийн захиргааны болон үйлчилгээний ажилтнуудыг хамруулжээ.

2019 онд Та бүхнийг хууль тогтоомж, жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажил үүргээ зохих ёсоор гүйцэтгэж, илүү үр дүнтэй, амжилттай ажиллахыг хүсье.

Та бүхэндээ шинэ жилийн баярын мэнд дэвшүүлж, аз жаргал, эрүүл энхийг хүсэн ерөөе.

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД  
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР**

2018 оны 12 дугаар сарын 24-ний өдөр